



## ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

**Байгууллагын нэр:** Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль

**Сургалтын хөтөлбөрийн нэр:** Бизнесийн удирдлага

1. Санхүүгийн менежмент
2. Хүний нөөцийн менежмент
3. Маркетингийн менежмент
4. Мэдээллийн системийн менежмент
5. Олон улсын бизнесийн менежмент

**Индекс:** D041301

**Шинжээчийн баг:**

Ахлагч:

Г.Болдбаатар

Гишүүд:

С.Энхсайхан

Б.Мөнхбаяр

Ц.Нансалмаа

Б.Ундрал

2018.05.15

# АГУУЛГА

Хуудас

<b>Товчилсон үгийн тайлбар</b> .....	4
<b>I.Магадлан итгэмжлэх үйл явц, төлөвлөлт</b> .....	5-6
<b>II.Сургалтын хөтөлбөрийн танилцуулга</b> .....	6
<b>III.Мэргэжлийн зөвлөлийн тодорхойлолт</b> .....	6
<b>IV. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт</b> .....	7-40
Шалгуур1:Хөтөлбөрийн төлөвлөлт.....	7-9
Шалгуур 2: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл.....	9-13
Шалгуур 3:Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.....	14-20
Шалгуур 4: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа.....	20-28
Шалгуур 5:Багшийн үйл ажиллагаа.....	28-32
Шалгуур 6: Сургалтын үйл ажиллагаа.....	32-35
Шалгуур 7:Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө.....	35-37
Шалгуур 8:Чанарын үнэлгээ, баталгаажилт.....	38-39
Дүгнэлт .....	40
<b>Хавсралт</b>	
I. Шинжээчдийн сургууль дээр ажилласан хуваарь.....	41
II. Ярилцлагад оролцсон оролцогчдын жагсаалт	
1. Багш нарын нэрс.....	42
2. Оюутны нэрс.....	43
3. Ажил олгогчдын нэрс.....	43-44
4. Төгсөгчдийн нэрс.....	44
III. Сургуулиас ирсэн албан бичиг .....	45
<b>V.Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр</b> .....	
<b>VI. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр</b> .....	

## Товчилсон үгийн тайлбар

1. ШУТИС-Шинжлэх ухаан, технологийн их сургууль
2. БУХС-Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
3. БУСТА-Бизнесийн удирдлагын сургалтын төлөвлөгөөний алгоритм
4. CDIO-Concieve Design Implement Operate
5. ACBSP-Accreditation Council for Business Schools and Programs
6. ЭЕШ-Элсэлтийн ерөнхий шалгалт
7. КТМС-Компьютер, техник менежментийн сургууль
8. БСШУСЯ-Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам
9. ШУА-Шинжлэх ухааны академи
10. БУ-Бизнесийн удирдлага
11. ЭШ-Эрдэм шинжилгээ

## I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	ШУТИС, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль MUST, School of Business Administration and Humanities, Business administration department	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Бизнесийн удирдлага –Business administration 1. Санхүүгийн менежмент-Financial management 2. Хүний нөөцийн менежмент-Human resource management 3. Маркетингийн менежмент-Marketing management 4. Мэдээллийн системийн менежмент-Management of information system 5. Олон улсын бизнесийн менежмент-Management of International business	
<b>Индекс</b>	D041301	
<b>Шинжээчид</b>	Шинжээчдийн нэр, ажил, албан тушаал: <b>Багийн ахлагч:</b> 1. Г.Болдбаатар-доктор (Ph.D), профессор. Хүмүүнлэгийн их сургуулийн Бизнесийн сургуулийн профессор. <b>Гишүүд:</b> 2. С.Энхсайхан-Удирдлагын академийн дэд профессор 3. Б.Мөнхбаяр-Санхүү, эдийн засгийн их сургуулийн ректор 4. Ц.Нансалмаа-Хөдөө аж ахуйн их сургуулийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн дэд профессор 5. Б.Ундрал Номч IT консалтинг ХХК-ийн захирал.	
<b>БМИҮЗ-ийн зохицуулагч</b>	Б.Оюунчимэг	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b>
	2018-04-20	№40 Ажлын албаны захирлын тушаалаар Шинжээч томилогдсон.
	2018-04-23	№.11/18 Шинжээчидтэй гэрээ байгуулсан.
	2018-04-23	Шинжээчид өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээн авч, танилцсан.
	2018-04-26	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг зохицуулагчид хүлээлгэн өгсөн.
	2018-04-27	Зохицуулагч сургууль дээр очиж шинжээч ажиллах бэлтгэлийг хангуулсан.
	2018-05-2,3	Сургууль дээр ажиллаж, илрэл нотолгоотой танилцсан. Төгсөгчид, ажил олгогч, багш, оюутнуудын төлөөлөлтэй уулзсан.
	2018-05-15	Шинжээчид үнэлгээний тайланг зохицуулагчид хүлээлгэн өгсөн.
	2018-05-17	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авсан.
	2018-05-21	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг зохицуулагчид хүлээлгэн өгсөн.
	2018-05-25	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэж, ажлын албаны зохицуулагчид өөрийн үнэлгээний тайлангийн хамт хүлээлгэн өгнө.

	2018-06	Мэргэжлийн зөвлөлийн хурлаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж, шийдвэрлүүлнэ.
<b>Шалгуур шаардлага /журам/</b>		БМИҮЗ-ийн 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт БМИҮЗ-ийн дүрмийн 2.1-ийн “б” заалт, БМИҮЗ-ийн 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмын 2.2.9-2.2.18 заалт, БМИҮЗ-ийн 2015 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 05 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур”,

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

1959 оноос инженер-эдийн засаг, аж үйлдвэрийн удирдлага, зохион байгуулалт мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн 60 жилийн туршлагатай. 1992 оноос улс орон зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбоотой зах зээлийн эдийн засаг, менежмент, бизнесийн удирдлагын чиглэлээр сургалтын шинэ хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлсэн. Дээд боловсролын сургалтын тогтолцоонд 1998 онд кредит системийг тус хөтөлбөрт туршин нэвтрүүлсэн.

Бизнесийн удирдлагын багц хөтөлбөрөөр Санхүүгийн удирдлага, Хүний нөөцийн удирдлага, Маркетингийн удирдлага, Мэдээллийн системийн удирдлага, Олон улсын бизнесийн удирдлага 5 мэргэжлээр 4 жил 128 кредитийн багц хичээл судлан, бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгсөнө. Бизнесийн удирдлагын салбар нь 32 профессор, багш нартай. Нийт багш нарын 35 гаруй хувь нь эрдмийн зэрэг, цолтой. Багш нарын дундаж ажилласан жил 12.6 жил болно. 2014-2017 онуудад багш нар 20 орчим захиалгат төсөл, гэрээт ажил гүйцэтгэсэн байна.

Бизнесийн удирдлагын багц 5 хөтөлбөрийг (ACBSP) олон улсад 2013, 2015, 2017 онуудад тус тус магадлан итгэмжлүүлж, 2021 он хүртэл магадлан итгэмжлэл сунгагдсан байна. Дэлхийн эдийн засаг, бизнесийн сургуулиудын (Eduniversal International Scientific Committee) холбооноос 2008 онд хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын 1 навч, 2017 онд 2 навчтай болж, сургалтын хөтөлбөрын чанар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байна.

Бизнесийн удирдлагын хөтөлбөрөөр нийт 7000 гаруй мэргэжилтэн бэлтгэсэн байна. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин 90 гаруй хувьтай. 2017-2018 оны хичээлийн жилд нийт 650 гаруй оюутан суралцаж байна.

## III. Мэргэжлийн зөвлөлийн тодорхойлолт

Бизнес, удирдлагын чиглэлээр сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийх мэргэжлийн зөвлөл байгуулагдаагүй тул Ажлын албаны захирлын шийдвэрээр шууд шинжээчийн багийг ажиллуулсан болно.

## **IV. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

### **ШАЛГУУР 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ**

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### **1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага**

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байдал
- Төгсөгчийн /мэргэжилтний/ загвар
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал /ялгаатай, давуу, сул тал, сайжруулалт/

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд түүний бүтцэд шинжилгээ хийж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй салбаруудын мэргэжилтнүүдийн хэрэгцээг судалж, хэрэгцээтэй мэдлэг, ур чадварыг тодорхойлсон байна.
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг хөтөлбөрийг сайжруулах, төгсөгчдийн загварыг боловсруулахад тодорхой хэмжээгээр анхаардаг.
- Бизнесийн удирдлагын хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг тодорхойлж 21-р зууны мэргэжилтэнд зайлшгүй шаардагдаж буй хувь хүний төлөвшил, багаар ажиллах чадвар, судалгаа шинжилгээ хийх арга зүйг хэрэглэх чадвар, асуудлыг тодорхойлж, хөгжүүлэх, шийдвэрлэх гэсэн хүрээнд нарийвчлан тодорхойлсон нь сайшаалтай.

#### **Анхаарах асуудал:**

- Ижил төрлийн дотоод, гадаадын хөтөлбөрүүдтэй харьцуулсан шинжилгээ хийсэн боловч ямар үндэслэлээр уг сургуулиудыг сонгож авсан гэдэг нь тодорхойгүй тул шинжилгээний үр дүнг үйл ажиллагаанд ашиглахад эргэлзээтэй байдлыг бий болгож байна.
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийг тогтмол авдаг гэсэн мэдээлэл тайланд байгаа боловч ажил олгогч, төгсөгчидтэй хийсэн уулзалтын хүрээнд тэдгээр оролцогч талуудын сэтгэл ханамжийг тогтмол хэмждэг тогтолцоо бүрэлдээгүй болох нь ажиглагдлаа.

#### **Зөвлөмж:**

1. Оролцогч талуудтай харилцах, мэдээлэл цуглуулах, түүнийг үйл ажиллагаандаа ашиглах арга зүйг тодорхой болгох
2. 5 мэргэжлийн хөтөлбөрийг нэг индексийн хүрээнд зохион байгуулж байгааг ШУТИС болон БУХС-ийн стратеги, бодлоготой уялдуулан тодорхой болгох
3. Орчны шинжилгээнд тулгуурласан стратеги бодлого, түүнтэй уялдуулан харьцуулсан шинжилгээ болон хэмжилтүүдийг хийх нь судалгаа, шинжилгээний үр дүнгийн ач холбогдолыг нэмэгдүүлэх талтай.

## **1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго**

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

### **Үзүүлэлт нотолгоо:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, онцлог, сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал
- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын арга зүйн олон улсын дэвшилтэд загварт суурилсан БУСТА болон CDIO загварыг хэрэгжүүлж байгаа нь тухайн сургуулийн бусад бизнесийн сургуулиудаас ялгарах онцлогийг харуулж байна.
- UNIMIS удирдлагын мэдээллийн системийг ашиглаж, багш бүрийн явцын болон эцсийн шалгалтын үнэлгээ, түүний тархалтын шинжилгээг хийж байгаа нь агуулга, арга зүйг боловсронгуй болгох дүгнэлт хийхэд ихээхэн ач холбогдолтой байна.

#### **Анхаарах асуудал:**

- Мэргэжлийн хөтөлбөрүүдийн хөгжлийн асуудал оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаанаас хэрхэн үндэслэж байгаа нь тодорхой харагдахгүй байна.
- Оролцогч талуудад чиглэсэн үйл ажиллагааг Зураг 1,2,6-д харуулсан боловч давтамж, ямар мэдээллийг хэрхэн цуглуулдаг зэрэг нь тодорхойгүй байна.
- Төгсөгч, ажил олгогчдын уулзалтын хүрээнд сүүлийн жилүүдэд тэргүүлэх байр сууриа алдаж байгаа гэсэн санал олон удаа гарч буй боловч бодлогын чанартай арга хэмжээ хэрэгжүүлээгүй харагдаж байна.

#### **Зөвлөмж:**

1. Үнэлгээний систем тодорхой боловч явцын, дундын, нэгтгэсэн үнэлгээг хэрхэн хийдэг /бие биенээ дэмжих, нотлох системтэй үнэлгээний систем/ нь тодорхойгүй, албажуулаагүй байна. Үнэлгээний процесс, хэлбэр, аргачлалын хувьд цогц байдлаар тодорхойлж ашиглах нь үйл ажиллагааг тасралтгүй сайжруулахад маш чухал нөлөө үзүүлэх юм.
2. БУХС-ийн төгсөгчийн загварыг шинэчлэн боловсруулахдаа ШУТИС болон БУХС-ийн эрхэм зорилго, стратегийн зорилгуудад үндэслэдэг байхаар үйл ажиллагааны горим албажуулах нь зүйтэй.
3. Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх чиг үүрэг, үр дүнг хөтөлбөрийн шинэчлэлд хэрхэн ашиглах үйл ажиллагааг албажуулж тодорхой болгох нь хувь хүнээс хамаарсан эрсдэлийг бууруулах ач холбогдолтой юм.

## **1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

### **Үзүүлэлт нотолгоо:**

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдал
- Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байдал

- Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Олон улсын чанарын баталгаажуулалтын байгууллага болох ACBSP, BID, Eduniversal зэрэг байгууллагын шалгуур, шаардлагыг хангаж ажиллаж байгаа нь нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байгааг илэрхийлж байна.
- Мэргэжил тус бүрийн залгамж холбоог хөтөлбөрийн дизайн хэлбэрээр дүрсэлж харуулсан нь багш, суралцагчдийг хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд зөв чиглүүлж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилт нь практик ур чадвар болон хувь хүний ур чадваруудыг эзэмшүүлэхэд учир дутагдалтай байгаа нь төгсөгч, ажил олгогчдын уулзалтаар харагдаж байгаа боловч уг чадваруудыг олгох системтэй төлөвлөлт, үйл явц, хэмжилт байхгүй байна.
- Сургалтын хөтөлбөрийн хувьд үр дүнг тодорхойлох хэмжих оролдлогуудыг үр дүнтэй хэрэгжүүлсэн боловч хичээлийн төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн түвшинд хөтөлбөрийн үр дүнтэй уялдах, түүнийг хэмжих аргачлалыг боловсронгуй болгох шаардлагатай.

#### **Зөвлөмж:**

1. Хувь хүний ур чадваруудыг хичээл бүрийн үр дүнд тодорхой тусгах, түүнд хэрхэн хүрч байгааг хэмжих нь төгсөгчдөд дутагдаж буй ур чадваруудыг олгоход чиглэсэн томоохон шинэчлэл болно.
2. Хичээл, сэдэв бүрээр хөтөлбөрийн эцсийн үр дүнтэй хэрхэн уялдаж байгааг тодруулсанаар хичээл бүрээр олгох хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, хэрхэн хэмжихийг тодорхой болгох боломжтой болох юм.
3. Үр дүн – Агуулга – Арга зүй – Үнэлгээ- Сайжруулалт гэсэн циклийг хөтөлбөрийн бүх түвшинд хэрэгжүүлэх нь хөтөлбөрийн үр дүнг сайжруулахад чухал нөлөөтэй юм.

**1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **ШАЛГУУР 2. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт хийх

### **2.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Эрүүл, аюулгүй, тохилог орчинг бүрдүүлсэн байдал
- Тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори, урлангийн хангалт, ашиглалтын байдал
- Бие даан болон багаар ажиллах орчны хангалт

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага.**

- Оюутнуудаа суралцах орчноор хангах зорилгоор бүх талын үйлчилгээнүүдийг хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай. Багш, оюутнуудад зориулсан фитнес, эрүүл мэндийн төв, сэтгэл зүйн төв, хоолны газар, номын сан, эрдэм шинжилгээний номын сан, спорт заал, хичээлийн лабораториуд, wifi өрөө, оюутнуудын багаар ажиллах

чөлөөт орчин ажиллуулж байгаатай шинжээчид газар дээр нь очиж танилцлаа.

- Төв ШУТИС дээр байрлах эрүүл мэндийн төвөөр багш, оюутнууд өглөө 8 цагаас оройн 8 цаг хүртэл шүд, дотрын эмчээс нарийн мэргэжлийн үйлчилгээнүүдийг авдаг бол БУХС-ийн дотуур байранд байрлах эмнэлгийн анхан шатны тусламжийн төвөөс ажлын цагуудаар дусал, тариа хийлгэх, татлага, шарлага хийлгэх зэрэг 11 төрлийн үйлчилгээг авах боломжтой нь багш, оюутнуудад том давуу талыг олгож байна. Мөн шинжээчдийг газар дээр ажиллаж байх үед нийт оюутнуудаас БЗХӨ, тэмбүүгийн шинжилгээ аваад лаборатори руу явуулдаг гэж байсан нь онцлог байсан.
- Сургуулийн 1,2,3 давхарт нийт 51 хүний суудал бүхий wifi, цахилгааны залгуур, цэвэршүүлсэн халуун хүйтэн усны төхөөрөмж бүхий багаар ажиллах чөлөөт орчныг бүрдүүлсэн байна. Мөн 1-р давхрын лабораторид оюутны картаа үзүүлээд үнэгүй wifi ашиглах өрөө ажиллуулж байсан нь оюутнуудыг багаар болон ганцаараа зөөврийн компьютер дээр ажиллах боломжийг бүрдүүлсэн нь сайшаалтай байна.
- Оюутны дотуур байрны өрөө болгонд интернэтийн оролт байсан бөгөөд йогийн өрөө, багш ажилтнуудын хүүхдийн цэцэрлэг, 24 цагийн номын сан ажиллаж байсан нь сурч, ажиллаж хөдөлмөрлөх таатай орчинг бүрдүүлж байна. Хүүхдийн цэцэрлэгт багш нарын хүүхдээс гадна нэг оюутны хүүхэд суралцдаг байна.

#### **Анхаарах асуудал:**

- Эмнэлгийн анхан шатны тусламжийн төвөөр үйлчлүүлэгч оюутнуудын тоо жил бүр тогтмол буурсан байсан. Оюутнуудаас эмнэлгийн үйлчилгээний талаар уулзаж асуухад дийлэнх нь эмнэлэг байдаг гэдгийг мэддэг боловч очиж үзүүлэх онцгой шаардлага байдаггүй гэж хариулсан.
- Өөрийн үнэлгээний тайланд интернэтийн хурд тогтмол өссөн үзүүлэлттэй байсан боловч газар дээр нь очиж ажиллах үед сургуулийн wifi-н хурд болон хүртээмж муу байсан. Суралцаж буй оюутнуудтай уулзах үед “Сургуулийн төв шатны дагуу wifi байдаг бөгөөд захын ангиудад wifi хүрэлцдэггүй. Өөрсдийн нэгжээр дата худалдан авч ашигладаг. Сургууль сарын wifi эрх зардаг боловч wifi-н хурд, хүртээмжнээс болоод сургуулийн wifi ашигладаггүй.” гэж хэлж байсан. Мөн 2017-2018 онд багш, хичээл болон сургалтын орчны талаар авсан асуулга судалгаанд ороцлогчдын 36,36% нь интернэтийн хурд хангалтгүй, 63,64% нь дунд гэсэн үнэлгээ өгсөн байна. Оюутнууд, багш нарын хувьд бүгд онлайнаар UNIMIS болон moodle-г албан ёсоор ашиглаж байгаа тохиолдолд wifi-н хурдаа сайжруулах хэрэгтэй гэж үзэж байна.
- Багш, оюутнуудыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж эрүүл чийрэг бие бялдартай болгох зорилгоор фитнесийн өрөөг байгуулан ажиллуулж байгаа нь сайн туршлага юм. Гэвч өөрийн үнэлгээний тайланг харахад жил бүр тогтмол үйлчлүүлэгчийн дундаж тоо буурсан үзүүлэлттэй байна. 2012 онд тогтмол үйлчлүүлдэг үйлчлүүлэгчийн дундаж 32 байсан бол 2018 онд 22 болж бууржээ. Газар дээр нь очиж ажиллах үед фитнесийн өрөөний агааржуулалт тааруухан байсан. Мөн суралцаж буй оюутнуудтай уулзахад “Фитнесийн мэргэжлийн багш байхгүй, агааржуулалт муу, гүйлтийн замаас өөр бүрэн ажиллагаатай тоног төхөөрөмж байхгүй учраас фитнесээр үйлчлүүлдэггүй” гэсэн.
- Багш, оюутнуудынхаа сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд анхаарч сэтгэл зүйн төв байгуулсан нь сайн туршлага юм. Гэвч суралцаж буй оюутнуудтай уулзах уулзалтанд ирсэн оюутнуудын 80% гаруй хувь нь сургуулийн дэргэд Сэтгэл зүйн төв байдгийг мэдэхгүй байсан бөгөөд үйлчлүүлсэн нэг оюутны хувьд сэтгэл зүйн төвийн байршил нь ойлгомжгүй, мөн байнгын эмч байдаггүй, урьдчилан цаг авсан тохиолдолд эмч нар ирдэг нь үйлчлүүлэхэд төвөгтэй байдаг гэсэн.

#### **Зөвлөмж:**

1. Олон жилийн өмнө баригдсан барилга учраас сургуулийн нийт анги танхимууд болон коридор, оюутны дотуур байрыг нийтэд нь засвар хийх шаардлагатай. Хэсэгчлэн засвар хийсэн нь засвар хийгээгүй хэсгээ илүү муутгаж харагдуулж байсан.
2. Компьютерийн лабораторид маш олон компьютерийг хооронд нь шахаж байрлуулсан нь

газардуулга болон хөдөлмөрийн аюулгүй байдлын хувьд анхаарах шаардлагатай байна. Мөн ямар нэгэн эрсдэл үүссэн тохиолдолд жишээлбэл гал гарсан тохиолдолд ямар арга хэмжээ авах аюулгүй ажиллагааны зааварчилгаа ангид байхгүй байна.

3. Сургуулиас багш, оюутнуудад зориулан үзүүлж байгаа үйлчилгээг оюутнууддаа сурталчилан таниулж, тэдний оролцоо, хамрах хүрээг нэмэгдүүлэх тал дээр тогтмол ажил зохион байгуулах хэрэгтэй. Учир нь сургуулийн зүгээс олон сайхан үйлчилгээ гаргасан ч багш, оюутнууд нь хамрагдан үйлчлүүлэхгүй бол үйлчилгээг нэвтрүүлсэн гол зорилгоо биелүүлж чадахгүй байх эрсдэлтэй юм.

## **2.2 Сургалтын хэрэглэгдэхүүн, хэрэгсэл**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

### **Үзүүлэлт нотолгоо:**

- Программ хангамж, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хүртээмж
- Хичээл практикийн материаллаг нөөц, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, хэрэглэгдэхүүний хүртээмж, хэрэглээ
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн хүртээмж

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургуулийн удирдлагын үйл ажиллагаанд 2003 оноос эхлэн хөгжүүлж байгаа UNIMIS системийг ашиглаж байгаа нь шилдэг туршлага юм. Шинээр элсэгчдийн зураг, регистрийн дугаар, овог, нэр гэх мэт шаардлагатай мэдээллүүдийг Иргэний бүртгэл мэдээллийн төвөөс авч, элсэгчийн ЭЕШ-ын оноог Боловсролын үнэлгээний төвөөс авч, сургалтын төлбөрийн мэдээллийг Голомт банк, Хаан банк, Улаанбаатар хотын банкуудаар дамжуулан бодит цагийн горимд оюутнуудын мэдээллийн баазыг хамгийн сүүлийн үеийн алдаагүй, үнэн зөв мэдээллээр бүрдүүлж байгаа нь сайшаалтай.
- Оюутнууд сургалтын төлөвлөгөө, хичээлийн хуваарь, хичээлийн дүн зэрэг сургалттай холбоотой мэдээллийг шууд онлайнаар ил тод, шуурхай авч байна. Багш нарын хувьд оюутнуудын дүнд анализ хийх болон бусад шаардлагатай тайлан мэдээг хурдан авах боломжтой байна. Удирдлагуудын хувьд бодит цагийн горимд одоо цагийн мэдээллийг өмнөх жилүүдийн мэдээлэлтэй харьцуулан харж байгаа нь богино хугацаанд зөв шийдвэр гаргах боломжийг олгож байгаагаараа давуу талтай.
- Салбарын профессор, сургалтын алба болон зөвлөх багш нараас хэрхэн мэдээлэл авах үйл ажиллагааны процессийг оюутны гарын авлага болон холбогдох вэб сайтуудад тусгадаг нь оюутнуудыг заавар, удирдамж, зөвлөмжөөр цахим орчинд болон оффлайн орчинд маш сайн хангаж байна. Бүх багш, оюутнууд UNIMIS системийг ашиглан тогтмол мэдээллээ шинэчилдэг бөгөөд UNIMIS-н хөгжүүлэлтийг тусдаа баг тогтмол сайжруулж байгаа нь шилдэг туршлага юм.
- Хичээлийн бие даалтын цаг тусдаа хичээлийн хуваарь дээр тавигдаж тухайн цагтаа багш оюутнуудад зөвлөгөө өгч ажилладаг нь оюутнуудыг хичээлдээ илүү сайн суралцах боломжийг олгож байна.
- Хичээлийн явцад судлах лекц, семинар болон бусад судлах материалуудыг Moodle системд оруулдаг нь сайн туршлага юм.
- Бизнес симуляци хичээлийн хүрээнд GreenERP ашиглан бизнесийн удирдлагын хөтөлбөрөөр суралцаж байгаа таван мэргэжлийн оюутнуудыг нэг баг болгон бизнес кейсүүдийг шийдвэрлүүлж байгаа нь сайн туршлага юм. Ажил дээр гарахаасаа өмнө бусад менежерүүдийн ажил үүрэг, шийдвэрлэх асуудлуудыг мэдэж, ERP систем дээр мэдээллээ оруулж, тайлан гаргаж байгаа нь оюутнуудын хувьд үр дүнтэй туршлага юм.

- Өөрийн үнэлгээний тайланд лабораторид ашиглаж байгаа суурин компьютерийн тоо өссөн үзүүлэлттэй байсан. Газар дээр нь ажиллаж суралцаж буй оюутнуудтай уулзахад лабораторийн хичээлийн үед оюутан бүрт нэг компьютер оногдож чадаж байгаа гэсэн нь сайшаалтай.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын удирдлагын Moodle системийг ашиглаж байгаа боловч зарим багш нар facebook, өөрийн блогийг сургалтад ашиглаж байна. Moodle-г албан ёсоор сургалтын удирдлагын систем гэж үзэж байгаа тохиолдолд өдөр тутмын сургалтын бүхий л үйл ажиллагаанд нэгэн жигд ашиглахад анхаарч ажиллах шаардлагатай. Оюутнуудын хувьд нэг эх сурвалжаас бүх мэдээллээ авдаг байх нь чухал юм.
- Бизнес симуляци хичээл дээр ашиглаж байсан GreenERP-г серверийн хүчин чадал, ачаалал хүрэхгүй байгаа асуудлаас шалтгаалан 2017-2018 оны хичээлийн жилд ашиглаж чадахгүй байгаа юм байна. Суралцаж байгаа оюутнуудтай уулзаж ярилцахад тухайн хичээл нь өндөр үр дүнтэй гэж байсан учир энэхүү хичээлээр ERP дээрээ үргэлжлүүлэн ажиллахад анхаарах хэрэгтэй гэж үзэж байна.
- Төгсөгчидтэй уулзах үед нэг програмыг илүү нарийвчлан судалсан байсан бол ажлын байран дээр илүү амжилттай байх боломжтой байсан гэдэг саналыг хэд хэдэн төгсөгчид хэлж байсан учир энэ тал дээр илүү анхаарах хэрэгтэй гэж үзэж байна.

#### **Зөвлөмж:**

1. Сүүлийн жилүүдэд хүүхэд залуучуудын цахим гадуурхал, цахим гэмт хэрэгт холбогдох тоо ихэссэн. Үүнийг багасгахын тулд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд олон арга хэмжээ, ажлуудыг хийж байна. Гэвч үр дүн нь хангалттай биш байгаа. Тиймээс оюутнуудыг цахим гэмт хэргээс сэргийлж, хол байлгахын тулд цахим хэрэглээг нь зөв зүйтэй байлгахад анхаарч багш нар олон нийтэд зориулсанаас бусад мэдээллийг фейсбүүкээр дамжуулалгүй өөрсдийн албан ёсны системүүдийг ашиглахыг зөвлөж байна. БУХС-ийн хувьд Moodle, UNIMIS болон бүх оюутан, багш нар нь албан и-мэйл хаягтай зэрэг олон давуу талууд байгаа учир фейсбүүк ашиглахгүйгээр мэдээллээ дамжуулах, зөв цахим хэрэглээг нэвтрүүлэх үндсэн суурь бүрдсэн байна гэж харж байна.
2. Багш, оюутнууд болон төгсөгчдөөс авах сургалтын хэрэглэгдэхүүн, програм хангамжийн талаарх сэтгэл ханамжийн судалгаандаа хичээл дээр ашиглая гэж бодож байгаа ч ашиглаж чадахгүй байгаа болон сурья гэж бодож байгаа боловч заахгүй байгаа программ, сургалтын хэрэглэгдэхүүний талаарх асуулгыг нэмэх хэрэгтэй гэж харж байна.

### **2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж, хэрэглээ
- Виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим эх үүсвэрүүдийн байдал
- Цахим орчны хүртээмж, хэрэглээ
- Сургалт, судалгааны лицензтэй программын ашиглалтын байдал

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Төв ШУТИС дээр байрлах нэгдсэн номын сан болон БУХС дээр байрлах оюутны номын сан, эрдэм шинжилгээний номын сан, дотуур байрны номын сан, UNIMIS-н дэд систем e-library зэрэг хэд хэдэн номын сангаар нэг оюутан үйлчлүүлэх боломжтой байгаа нь багш, оюутны хувьд маш том боломж юм. Төв ШУТИС-н

номын санд хэд хэдэн хэвлэх үйлдвэрийн нэрэмжит номын танхимууд ажиллаж, хэвлэх үйлдвэрт номыг зохиогчийн эрхтэйгээр багш, оюутнуудад олшруулж өгч байсан. Мөн хуучирсан номыг сэргээн засварлаж дахин ашиглаж байсан нь сайн туршлага байлаа.

- UNIMIS дээрээс оюутан өөрийн нэр дээр бүртгэлтэй байгаа номнуудын жагсаалтыг харж чадаж байсан нь онцлог байсан.
- Ebsco, springer зэрэг цахим эх сурвалжуудаас ШУТИС-ийн багш, оюутнууд үнэгүй цахим ном, судалгааны материал унших боломжтой нь маш том давуу тал юм.
- <https://lib4u.net/?lib=must> хаягаар аль номын санд өөрийнх нь хайж байгаа ном бэлэн байгааг харж чадаж байсан нь давуу талтай байна.

#### **Анхаарах асуудал:**

- Оюутнуудтай уулзах үед цахим номын сангийн <https://lib4u.net/?lib=must>, <http://www.must-library.edu.mn/> хоёр хаягийг алийг нь ямар зорилгоор ашиглах нь тодорхойгүй, олон зэрэг хаягаар ороход оюутнуудын хувьд ойлгомжгүй байдаг байна. Мөн БУХС дээр байрлах номын сангаас хэвлэмэл ном авахад ямар ч асуудалгүй байдаг учир оюутнууд төв ШУТИС-н номын сангаар ихэнхдээ үйлчлүүлдэггүй байна. Цахим номын хувьд багш нар pdf хэлбэрээр фейсбүүкээрээ өгчихдөг учраас цахим номын сангаар үйлчлүүлэх хэрэгцээ гардаггүй гэж уулзалтын үед хариулж байсан. Энэ тал дээр анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.
- Өөрийн үнэлгээний тайланд дурьдсанаар цахим номын сангийн сурах бичиг болон цахим контентийн баяжилт 2014 оноос хойш хийгдээгүй байна. Орчин үед хүмүүсийн хэрэглээнд цахим номын хэрэглээ өргөнөөр орж ирж байгаа учраас багш, оюутнуудаа цахим ном, сурах бичиг унших соёлд сургах хэрэгтэй гэж үзэж байна.
- <https://lib4u.net/?lib=must> хаягаар монгол хэл дээрх цахим ном гэж хайхад хоёрхон номын илэрц гарч ирсэн нь хангалтгүй байна.
- Эрдэм шинжилгээний номын сангийн хувьд газар дээр нь ажиллахад фонтны дийлэнхийг төгсөгчдийн дипломууд эзэлж байсан бөгөөд тэдгээрийг онлайнаар шүүх боломжгүй байсан.

#### **Зөвлөмж:**

1. Оюутан өөрөө номын сангаас авсан номын жагсаалтаа харж чадаж байгаа учраас багш нар тухайн оюутны номын сангаас ямар ямар ном авч байна гэдгийг харж анализ хийх боломжтой гэж бодож байна.
2. Файлаа багш нар оюутнуудад тараахын оронд цахим номын сангаар дамжуулан хүргэвэл аль сурагч цахим номоо авч ашиглаж чадаж байна гэдэгт анализ хийх боломж бүрдэнэ гэж харж байна.
3. Төгсөгчидтэй хийх уулзалтын үеэр их сургуульд сурч байхдаа англи хэлний чадвараа илүү хөгжүүлж чадсан бол амжилттай ажиллах боломжтой байсан гэж хэд хэдэн төгсөгч хэлж байсан. Үүнтэй холбоотойгоор сургалтын төлөвлөгөөнд тусгай мэргэжлийн англи хэл гэдэг хичээл нэмсэн нь сайшаалтай. Үүнтэй холбоотойгоор цахим номын сандаа аудио хичээл бүхий англи дээрх цахим номын баяжилт хийх хэрэгтэй гэж үзэж байна. Төв ШУТИС, БУХС-ийн номын санд ийм төрлийн цахим болон хэвлэмэл ном бараг байхгүй байна.
4. Багш, оюутнуудаас хэрэгцээ, шаардлагатай номын судалгааг асуулгадаа нэмвэл илүү үр дүнтэй гэж үзэж байна.

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **ШАЛГУУР 3. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

#### **3.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

##### **Үзүүлэлт нотолгоо:**

- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдал
- Хөтөлбөрийн нэгжийн /тэнхим, профессорын баг, хөтөлбөрийн хороо/ шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш, суралцагчдын оролцоог нээлттэй, ил тод хангасан байдал
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудын хэрэгжилт
- Урт болон богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ механизм
- Санал, гомдол хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагаа, систем бүрдсэн байна.
- Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэх ажлын үнэлгээ, гүйцэтгэлийн болон үр дүнгийн урамшууллын хэрэгжилт

##### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Удирдлагын болон сургалтын үйл ажиллагаандаа UNIMIS-ийн цогц програм хангамжийг бүрэн ашиглаж сургуулийн мэдээллийн нэгдсэн баазыг үүсгэж, дотоод хяналт-шинжилгээ, чанарын үнэлгээг тогтмолжуулахын зэрэгцээ бүрэн цахимжих боломжийг бүрдүүлж ажиллаж байгаа нь сайшаалтай байна.
- UNIMIS системийг хэрэглэснээр сургалт, эрдэм шинжилгээ, удирдлага зохион байгуулалтыг электрон хэлбэрт шилжүүлэн нэгж хэсгүүдийн хоорондын үйл ажиллагааг уялдуулан иж бүрэн цогц байдлаар ажиллаж байгаа нь шилдэг туршлага юм.
- Сургалттай холбоотой бүх тайлан мэдээг маягт тайлангийн стандартын дагуу гаргах, оюутанг элсэн орохоос эхлэн төгсөх хүртэлх сурлагын үзүүлэлт, төлбөрийн болон бусад дагалдах бүх мэдээллийг бүрдүүлэн суралцагчийг төгсөх бүх ажиллагаа бүгд автоматжуулагдсан байгаа нь давуу тал гэж үзэж байна.
- Багш нар UNIMIS-ээс гадна цахим сургалтын MOODLE [www.sbh.edu.mn/moodle](http://www.sbh.edu.mn/moodle) системийг ашиглаж хичээлийн страндарт, агуулга, нэмэлт материалыг оруулж, оюутнууд нь өөрийн эрхээр нэвтрэн орж мэдээлэл авах байдлаар хичээлийг судалдаг болсноор багш оюутны харилцаа холбоо улам ойртоход чухал алхам болсон байгаа давуу тал байна.
- Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн төлөвлөлтийн удирдлага зохион байгуулалт, хэрэгжилт үнэлгээ нь салбарууд дээр төвлөрдөг учир салбарын багш нар мэргэжлийн багийн зохион байгуулалтаар сургалтаа төлөвлөн хэрэгжүүлж, дэд профессорууд ахлан мэргэжлийн хөтөлбөрийн шинэчлэл, мэргэжлийн бодлого, сургалтын агуулга хэлэлцдэг нь хөтөлбөрийн нэгжийн шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш, суралцагчдын оролцоог нээлттэй, ил тод хангаж ажиллахад илүү үр дүнтэй байдаг байна.
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмууд болон түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг цаг тухай бүрд нь захирлын зөвлөл,

салбарын хурал, багш нарын хурал болон багш нарын мэйл хаяг, UNIMIS-ийн багшийн программаар дамжуулан багш, ажилчдад хүргэж хэрэгжүүлдэг онцлогтой байна.

- ШУТИС-ийн мастер төлөвлөгөө, БУХС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, салбар нэгжийн ажлын төлөвлөгөөг өөр хооронд нь уялдуулан ажиллаж байгаа нь сургуулийн удирдлага, зохион байгуулалт, хяналт болон сургалтын хөтөлбөрийн шинэчлэлт, хэрэгжилтийн чанарт таатай нөлөө үзүүлж байна. Хөтөлбөрөө АНУ-ын ACBSP магадлан итгэмжлэлийн байгууллагаар магадлан итгэмжлүүлсэн нь сургуулийн үйл ажиллагаа болон сургалтын хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн чанар, стандарт олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн болохыг гэрчилж байгаа ба ACBSP магадлан итгэмжлэлээ хадгалах зорилгоор 2 жил тутамд ахиц дэвшилийн тайлан бичиж баталгаажуулдаг нь хөтөлбөрийн ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээний механизм бүрдсэн болохыг харуулж байна.
- Санал гомдол, өргөдөл, сэтгэл ханамжийн талаарх мэдээллийг онлайнаар бүрдүүлж хөтөлбөрийн нийтлэг зорилгын хүрээнд дүн шинжилгээ хийж, үр дүнг нь үйл ажиллагаандаа тусган ажилладаг, нэгжийн удирдлагын ажлын цагийн хуваарьт оюутантай уулзах уулзалтын цаг төлөвлөгддөг туршлага бүрдсэн байна.
- Багшийн хөгжлийг дэмжих зорилгоор урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэхэд чиглүүлэн удирдлагаар ханган ажилладаг, багш нарыг гадаад дотоодод мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шилдэг багш нарыг тодруулан гадаад улс оронд сургалт, семинарт оролцох грант, мөнгөн шагналаар шагнаж урамшуулдаг, багшийн хөгжлийг дэмжих зорилгоор тодорхой хэмжээний зардлыг жил бүр нэгдсэн төсөвтөө тусгадаг сайхан уламжлал тогтсон нь сайшаалтай байна. Мөн БУХС нь дэргэдээ багш хөгжлийн төв байгуулан багш нараа чадваржуулах, хөгжүүлэх, судалгаа шинжилгээний ажлаа хийж гүйцэтгэх боломжоор хангаж ажиллаж байгаа нь шинэлэг, онцлог давуу тал гэж үзэж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаатай танилцахад зөвхөн төлөвлөсөн сургалтыг зохион байгуулахад голлон анхаардаг бөгөөд явуулж буй сургалт нь түүх соёл, сурган заах арга зүйгээр хязгаарлагддаг. Багш нарын хэрэгцээ, шаардлага, сонирхол, хөгжлийн талаар тэднээс судалгаа авч түүнд нь нийцсэн байдлаар сургалтаа төлөвлөдөггүй учир хамрагдалт багатай, үр дүн муу байдаг байна. Багш хөгжлийн төвийн үйл ажиллагааг чанаржуулах, сайжруулах шаардлагатай гэж үзэж байна. Багш хөгжлийн төвийн үйл ажиллагааг чанаржуулахын тулд багш нарын мэргэжлийн практик чадварыг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй. Тухайлбал,
  - Залуу багш нарт мэргэжлийн чиглэлийн судалгаа шинжилгээний ажил хийх, бүтээлээ олон улсын сэтгүүлд хэвлүүлэх, олон улсын судалгаа, шинжилгээний багт хамрагдах чадвар дадал олгоход анхаарах
  - Залуу багш нарын мэргэжлийн ном сурах бичиг, гарын авлага бичих дадал, чадварыг хөгжүүлэхэд анхаарах
  - Мэргэжлийн сургалтанд ашиглах монголын бодит кэйс материал бэлтгэх, боловсруулах чадвар олгоход анхаарах хэрэгтэй гэж үзэж байна

#### **Зөвлөмж:**

1. Багш хөгжлийн төвийн үйл ажиллагааг чанаржуулах, мэргэжлийн судалгаа шинжилгээний хамтын бүтээл туурвих, багш нарын мэргэжлийн практик чадварыг хөгжүүлэхийн тулд:
  - Залуу багш нарыг ахмад туршлагатай багш нартай хамтран мэргэжлийн чиглэлийн судалгаа шинжилгээний ажил хийх боломжийг бүрдүүлэхийн тулд дадлага туршлагатай профессоруудтай, судлаачидтай уулзалт, семинар,

workshop зохион байгуулах, тэднийг хамтран ажиллахад өөр хооронд нь холбох, зуучлах ажлыг зохион байгуулах,

- Бүтээлээ олон улсын сэтгүүлд хэвлүүлэх, олон улсын судалгаа, шинжилгээний багт хамрагдах боломжийг бүрдүүлэхийн тулд бизнесийн лидерүүд, бодлого боловсруулагчидтай уулзалт, семинар зохион байгуулж бодит кейс, судалгааны материалаар хангах, тэднийг хамтран ажиллахад өөр хооронд нь холбох, зуучлах ажлыг зохион байгуулах,
- Залуу багш нарыг ахмад туршлагатай багш нартай хамтран мэргэжлийн ном сурах бичиг, гарын авлага бичих, тэднээс суралцах, хамтдаа хөгжих боломж гүүр нь болж өгдөг төв байх
- Мэргэжлийн сургалтанд ашиглах монголын бодит кэйс материал бэлтгэхэд багш, ажил олгогч, төгсөгчдийг хамтран ажиллах боломжоор хангахад анхаарах хэрэгтэй гэж үзэж байна

### **3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны давтамж
- Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж, үр нөлөө

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- ШУТИС-ийн МООС буюу е-нээлттэй институтын нийтийн, нээлттэй, насан туршийн боловсрол дахь зайн сургалтын систем нь суралцагч, элсэгч, төгсөгч, эцэг эх, Засгийн газар, профессор багш нар, ажил олгогчид хэн ч бай ШУТИС-ийн болон дэлхийн их дээд сургуулиудын хичээлийн хязгааргүй их сангаас өөрийн сонирхсон хичээлийг сонгон суралцах боломж олгож байгаа шилдэг туршлага байна. Энэ нь их, дээд сургуулиуд хяналтын тоонд багтааж шинээр оюутан элсүүлдэг учир оюутнууд өөрийн хүссэн мэргэжлээр элсэн суралцаагүйгээс судалж буй хичээлүүддээ дургүй, багшийн зан харилцаанд дасахгүй зэрэг олон шалтгаанаар сургуулиас гарах буюу төгсөөд эзэмшсэн мэргэжлээрээ ажиллахгүй тохиолдлуудыг шийдэхэд туслах чиглэгдсэн нь онцлог юм.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал, төгсөгчид, ажил олгогчидтой хийсэн уулзалт, ярилцлагын дүн, хандлагаас харахад БУХС-ийн бэлтгэж буй мэргэжилтний хэрэгцээ нэмэгдэж байна гэж үзэхээр байна.
- Тайланд тусгагдсанаар Олон улсын боловсролын үнэлгээний Eduniversal байгууллагын чанарын үнэлгээний нэг навч ангилалаас хоёр навч ангилалд багтах болзолыг хангасан нь хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээг боломжит өндөр түвшинд хангаж буйг илтгэж байна гэж үзлээ.
- UNIMIS програмд хөдөлмөрийн зах зээлийг тандах судалгаа, оюутан хөдөлмөрийн биржийн мэдээлэл оруулсан, элсэгчдэд зориулсан элсэлтийн журам, ЭЕШ-ийн шалгалтад бэлтгэх эрдэмтэдийн видео, аудио лекцүүд, өөрийгөө хянах, үнэлэх тестүүд, төгсөгчдөдөө тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлж багш нарын видео, аудио лекцүүдийг оруулсан нь хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхижүүлэлтийн шилдэг бүтээлч арга төдийгүй, хамгийн хүртээмжтэй, маш их үр өгөөжтэй ажил байна гэж үзэж байна.
- Сургуулийн вэб сайт, сургалтын гарын авлага, мэдээллийн самбар, оюутны холбоо, мэргэжлийн өдөрлөгүүд, боловсролын яармаг, үзэсгэлэнд идэвхтэй оролцох зэрэг арга хэрэгслээр маркетингийн идэвхжүүлэлтийг сайн хийдэг давуу тал байна.

### **Анхаарах асуудал:**

- Е-нээлттэй институтын мэдээлэлд БУХС-ийн багш нарын хичээлийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, сайжруулах
- Өөрийн үнэлгээний тайланд дурьдсанаар сургуулийн бүтцийн өөрчлөлттэй холбоотой салбар сургуулийн КтМС нэр нь БУХС нэртэй болсноор уг нэр нь зах зээлд танигдаагүй, хэрэглэгч үйлчлүүлэгчид БУХС гэж шинэ сургууль гэсэн ойлголтоос болж элсэгчдийн чанар, тоо буурсан байна. Төгсөгчид, ажил олгогчидтой уулзахад мөн нэрийн асуудал дээр эмзэглэлтэй, БУХС нэр хоногшилтгүй байгаагаас сэтгэл ханамж буурч байгаа талаар ярьж байлаа.

### **Зөвлөмж:**

1. Е-нээлттэй институтын мэдээлэлд БУХС-ийн залуу багш нарын видео, аудио хичээлүүдийг оруулах. Багш нарын амжилт, бүтээлүүдийг нийтэд таниулах сурталчилахад удирдлага санаачлагатай ажиллах хэрэгтэй байна.
2. КтМС нэрийн брэнд хоногшилтыг БУХС нэрээр сольж брэндчилэх маркетингийн стратеги боловсруулан хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах

### **3.3 Төгсөлтийн дараах бодлого**

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа
- Үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Өөрийн үнэлгээний тайлан дахь мэдээлэл (төгсөгчдийн 50% дээд удирдлагын түвшинд, 22,7% ахлах, дунд түвшинд ажиллаж байна), төгсөгчидтэй хийсэн уулзалтын дүнгээс үзэхэд төгсөгчдийн карьер өсөлт хангалттай өндөр түвшинд байна гэж үзэж байна.
- Хөтөлбөрийн төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байх асуудлыг Е-нээлттэй институтын нийтийн, нээлттэй, насан туршийн боловсрол дахь зайн сургалтын системээр бүрэн хангаж байна. Е-нээлттэй институтын хүрээнд төгсөгчид төгссөний дараа багш нарынхаа болон дэлхийн их дээд сургуулиудын хичээлийн хязгааргүй их сангаас өөрийн сонирхсон хичээлийг сонгон тасралтгүй суралцах боломж олгож байгаа шилдэг туршлага байна.
- Өөрийн үнэлгээний тайланд дурьдсанаар бизнесийн удирдлагаар төгсөгчдийн удирдахуйн ур чадварыг төгөлдөржүүлэх, хөгжүүлэх, бүтээлч арга барил эзэмшүүлэх зорилго бүхий CEO нарт зориулсан Management excellence, Senior manager, карьер менежмент сургалтууд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байгаа нь багш нар өөрсдөө чадваржих, төгсөгчдөө хөгжүүлэх, хамтран суралцах, сургалтын бодит кэйс бүрдүүлэх зэрэгт ихээхэн ач холбогдолтой байх талаасаа сайшаал зөв ажлууд байна гэж үзлээ.
- 2014 оны сургуулийн бүтцийн өөрчлөлттэй холбоотой 2015 онд “ШУТИС-менежмент төгсөгчдийн холбоо” ТББ байгуулагдан сургуулийн байранд төгсөгчдийн өрөөг тохижуулах, сургуулийн сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх (лекцийн заал тохижуулсан), сургалтыг сайжруулахад идэвхи

санаачлагатай ажиллаж байгаа ба хийх ажлаа төлөвлөн ажиллаж байгаа давуу тал байна.

#### **Анхаарах асуудал:**

- БУХС-ийн бизнесийн удирдлагын бакалаврын сургалтыг төгсөгчдийн (10%) магистрын түвшинд, (2%) докторын түвшинд үргэлжлүүлэн суралцах асуудал хангалтгүй байна.
- Төгсөгчид, ажил олгогчидтой хийсэн уулзалт, ярилцлагын үр дүнгээс харахад мэргэшсэн нягтлан бодогч, мэргэшсэн маркетер, мэргэшсэн хүний нөөцийн менежер, мэргэшсэн санхүүч зэрэг цол нь ажлын байранд, карьер төлөвлөлтөд илүү ач холбогдолтой байгаа учир магистрын сургалтаас илүү төрийн бус, боловсролын бус байгууллагаас зохион байгуулж буй мэргэшсэний сургалтанд илүү хамрагдах сонирхолтой болоод байна.

#### **Зөвлөмж:**

1. Магистрын чанарыг сайжруулах, магистр зэргийн нэр хүндийг өсгөх ажлуудыг зохион байгуулах хэрэгтэй байна. Төгсөгчидтэйгөө хамтран ажиллах бодлого, механизм бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

### **3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа**

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, дүгнэлт
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо
- Олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд оролцсон тоо, үр дүн, ач холбогдол

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Олон улсын 9 их, дээд сургууль, олон улсын 4 судалгааны байгууллага, мэргэжлийн 3 байгууллагатай хамтран ажиллаж байна. Мөн гадаадын 6 сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж байгаа шилдэг туршлага байна.
- Тайваны үндэсний их сургуулиас 2 багш, 17 оюутан солилцоогоор ирж суралцсан байна. Тэтгэлэгт хөтөлбөрт 29 оюутан, 1 багш хамрагдсан давуу тал байна.
- Олон улсын хурал, семинар, арга хэмжээнд багш, оюутныг тогтмол оролцуулдаг. Ингэснээр багш нарын болон суралцагчдын мэргэжлийн ур чадвар, мэдлэг өссөн үр дүн гарчээ. 1 багш Ph.D хамгаалсан, 2 багш шилдэг багш болсон, 8 багш олон улсын түвшинд судалгааны ажлаа хэлэлцүүлсэн сайхан амжилтууд байна.

#### **Анхаарах асуудал:**

- Өөрийн үнэлгээний тайланд дурьдсанаар Олон улсын хамтын ажиллагаа хариуцсан ажилтан ажилладаг байхад олон улсын хөтөлбөрийн магадлан, олон улсын их сургуулиудын зэрэглэл тогтоох, гадаад харилцааны асуудал үр дүнтэй явагдаж байсан. Энэ ажилтаны орон тоо байхгүй болсоноор олон улсын харилцаа, хамтын ажиллагаа буурсан, зарим хамтын ажиллагаа зогссон байна.

#### **Зөвлөмж:**

1. Салбар сургуульд Олон улсын хамтын ажиллагаа хариуцсан ажилтанг ажиллуулж Олон улсын харилцаа, хамтын ажиллагаагаа сэргээн хөгжүүлэх

### **3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Хамтран ажиллах гэрээ, хэлцэл, ажлын үр дүн
- Хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, дүгнэлт
- Хамтын ажиллагааны арга, туршлага
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо үр дүн /багш, суралцагчдын зүгээс/

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хамтын ажиллагааны хүрээнд хурал семинар зохион байгуулах арвин туршлагатай байна. Эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулснаар багш нарын судалгааны ажлын чиглэлийг баяжуулж, судалгаа шинжилгээ хийх чадварыг нь нэмэгдүүлж байна гэж үзэж байна. Мөн багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын өгөөж өссөн байна.
- Боловсролын салбарын түвшинд 24, бизнесын байгууллагын түвшинд 19 сургалт, семинар, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан байгаа нь сайшаалтай байна.
- Сургалт, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах чадвар, туршлагатай уяир оюутнуудын судалгаа шинжилгээ хийх чадвар өсөж, мэргэжлийн уралдаан тэмцээнд оролцож тогтмол амжилт үзүүлж байна. Мөн үнэлгээ, төсөл, гэрээт ажил хийж гүйцэтгэх туршлагатай, мэргэжлийн олимпиад зохион байгуулахад тогтмол хамтран ажилладаг давуу тал байна.
- Багш ажилчдын хүүхдийн цэцэрлэг байгуулж ажилласан онцлог шилдэг вавуу тал байна. Олон нийтийг хамарсан арга хэмжээ хавар намрын их цэвэрлэгээнд тогтмол оролцдог сайхан туршлага байна.

##### **Анхаарах асуудал:**

- Хамтын ажиллагаа нь зөвхөн хурал семинараар хязгаарлагдсан байна. Ямар гэрээт ажил хэрэгжүүлсэн нь тодорхойгүй, албан ёсны гэрээ байгуулах, хамтран ажиллах санамж бичиг гарын үсэг зурах асуудал хангалтгүй байна.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулах хөрөнгө санхүүжилтын хэмжээг нэмэгдүүлэх
- Багш ажилчид, суралцагчдын зүгээс нийгэмд үзүүлдэг үйлчилгээ бага байна.

#### **Зөвлөмж:**

1. Start Up хүмүүсд зориулсан бизнесийн зөвлөгөө өгөх, мини бизнес инкубатор ажиллуулах, Бизнесийн байгууллагуудад, хувь хүмүүст санхүүгийн зөвлөгөө өгөх, санхүүгийн шинжилгээ хийх, Төрөл бүрийн захиалгат судалгаа хийх, төсөл, төлөвлөгөө боловсруулах зэргээр дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх
2. БСШУСЯ, ШУА-аас зарлаж буй төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.

### **3.6 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Төсөв, санхүүгийн бие даасан байдлын хөгжил
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв
- Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалт
- Төсвийн уламжлалт бус эх үүсвэр, бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилт

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээгээр бие даалтын коэффициент 0,6-аас дээш байгаа учир зохистой гэж үздэг. Тус сургуулийнх 0,91 байгаа нь санхүүгийн байдал өндөр байна гэж үзэхээр байна
- Нэг оюутанд ноогдох дундаж зардал 2194,1 буюу нийт зардлын 0,04% зарцуулагдаж байна
- 2015-2016 оны байдлаар хандив жилд дундажаар бэлэн мөнгөөр 23,1 сая төгрөг, биет хөрөнгө байдлаар 5,3 сая төгрөг байна.
- Зарцуулалтын хувьд анги танхим тохижуулалт, олимпиад тэмцээн, эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулахад зарцуулжээ.
- 2014-2015 онд гэрээт ажил, төслийн үр дүнгээр 94264,5 мянган төгрөг, орлого хандиваар 57787,3 мянган төгрөг, оюутны үйлчилгээний орлого 14616,9 мянган төгрөг, бусад орлого 61982,2 мянган төгрөг байсан бол 2015-2016 онд 13 төсөл, гэрээт ажлаар 148322,5 мянган төгрөг оруулж өссөн дүнтэй байна.

#### **Анхаарах асуудал:**

- Төлбөрийн чадварын шинжилгээгээр эргэлтийн хөрөнгөөр богино хугацаат өр төлбөрийг барагдуулах чадварыг илэрхийлэгч нөхөлтийн коэффициент буурсан байна. Ашигт ажиллагааны шинжилгээгээр өөрийн хөрөнгийн өгөөж буурсан байна. Хандив сүүлийн жилд буурсан байна.

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **ШАЛГУУР 4. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

#### **4.1 Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

##### **Үзүүлэлт нотолгоо:**

- Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан байдал
- Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх сургалтад хамруулж, мэдээлэл, гарын авлагаар хангасан байдал

##### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- БУ-ын бакалаврын зэрэг олгох хөтөлбөрт элсэгчдийг бүрэн дунд боловсролын гэрчилгээтэй, сургалтын дундаж үнэлгээ 83 ба түүнээс дээш, математик, гадаад хэлний ерөнхий шалгалтын оноо, ШУТИС-ийн босго оноог хангасан байх шалгуурыг тавьдаг байна. Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан байна.
- ЭШ-ийн дундаж оноо 2014 онд 500 байсан бол 2015 оноос 450 болж буурсан байна. ЭШ-ийн дундаж оноо ерөнхийдөө буурах хандлагатай байгаа ба элсэхийг хүсэгчдийн тоо 2014 оныхоос 2017 онд 1.8 дахин өссөн нь хэр нь элссэн оюутны тоо 20.6 хувиар буурсан төлөвтэй. Элсэхээр бүртгүүлсэн оюутны тоо өссөн нь элсэлтийн босго оноо буурсантай холбоотой байж болзошгүй. Бүртгүүлэгчдийн математикийн шалгалтын оноо 2014 онд 577.6 байснаа 2015 онд 545.5 болж буурснаа 2017 онд 561 болж өссөн боловч 2014 онын түвшинд хүрээгүй байна. Гадаад хэлний оноо тухайн жилүүдэд 583.9-өөс 553 болтол буурсан ба цаашид

өсөх хандлага ажиглагдахгүй байна. Тухайн асуудлаар бодит дүгнэлт хийн сайжруулах арга ажиллагааг тодорхойлсон байна.

- Шинээр элсэн суралцагчдыг чиглүүлэх сургалтад хамруулах дараах ажиллагааг явуулдаг байна. Үүнд:
  - Зөвлөх багш томилон ажиллуулах
  - Эрүүл мэндийн үзлэгт хамруулах
  - Сургуулиа танилцуулах хөтөлбөр хэрэгжүүлэх
  - Сургалтын үйл ажиллагааг танилцуулах уулзалт хийх
  - Амжилттай суралцах нь лекц
  - Шинэ оюутны төлөвшил цуврал лекц зэрэг болно.
- Шинээр элссэн оюутныг чиглүүлэх. мэдээлэл, гарын авлагаар хангах ажиллагаа оюутны вэб хуудсаар дамжин явагддаг байна.
- Зөвлөх багш ажиллуулдаг онцлог туршлага байна.

#### **Анхаарах асуудал:**

- Өөр өөр мэдлэг ур чадвар шаардагдах мэргэжлийн чиглэлээр нэг хичээлийн үнэлгээг ашиглах нь хэр оновчтой байгааг судлах
- Элсэгчдийн ерөнхий шалгалтын оноо болон Бизнесийн удирдлага хөтөлбөрийн суурь оноо буурч байгаа нь оюутнуудын ерөнхий түвшин буурч болзошгүйг анхаарах.
- Зөвлөх багшийн ажиллагааг сайжруулах талаар ажлууд зохион байгуулах

#### **Зөвлөмж:**

1. Өөр өөр мэдлэг ур чадвар шаардагдах мэргэжлийн чиглэлээр нэг хичээлийн үнэлгээг ашиглах нь хэр оновчтой байгааг судлан удирдах дээд байгууллагад танилцуулан шийдвэрлүүлэх ажил хийх нь зүйтэй байх.
2. Зөвлөх багшийг шинэ оюутантай ажиллахад нь бүх талаар туслан дэмжиж урамшуулах

#### **4.2 Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогмол, чанартай үзүүлдэг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Зөвлөх, хөгжүүлэхүйлчилгээний төлөвлөгөө, график, үрдүн
- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалт
- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлдэг байдал
- Суралцагч, төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг байдал
- Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусласан байдал

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, графикийг жилээр боловсруулан мөрдөж ажиллаж хэвшсэн байна. Зөвлөн туслах үйлчилгээг хариуцсан алба нь үйл ажиллагаагаа дараах үндсэн таван чиглэлээр төлөвлөн ажилладаг байна.
  - Сурч боловсрох үйл ажиллагааг дэмжиж туслах
  - Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, соёл урлаг, зан заншил, амьдрах ухаанд суралцах, өргөн хүрээний мэдлэг олгох
  - Оюутны төлөвшил, ёс зүй, харилцааг дээшлүүлэх

- Ажил эрхлэлт, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажил үйлчилгээ явуулдаг
- Судалгааны ажлын чадвар дадал эзэмшүүлэх зэрэг болно.
- Оюутанд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг:
  - Зөвлөх багшийн оролцоотой хийгдэх ажлууд
  - Оюутны сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ
  - Оюутны тэтгэлэг гэсэн 3 чиглэлээр боловсруулан хичээлийн жилийн туршид хэрэгжүүлдэг байна.
- Мөн Шилдэг элсэгч оюутныг шалгаруулж ректорын нэрэмжит тэтгэлэгт хамруулан 30 кредитийн урамшуулал олгож хичээлийн шинэ жилийн нээлт дээр алдаршуулдаг байна.
- Эдгээр нь оюутнуудыг хөгжүүлэх, зөвлөн туслах ажил тогтмолжсоныг харуулж байна.
- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч, сургуулийн эмч, оюутан хариуцсан ажилтнуудыг тусгайлсан орон тоогоор ажиллуулан ажил үүргийг нарийвчлан тодорхойлсон. Сэтгэл зүйн төв ажилладаг нь сайн туршлага байна. Шилдэг багшийг үндсэн 5 чиглэлээр шалгаруулдгийн нэг нь зөвлөх багш байгаа ба 2 жил дараалан тус хөтөлбөрийн багш нар шалгарсан байна.
- Суралцагчдад чиглэсэн үйлчилгээний чанарт үнэлгээ хийж түүний мөрөөр сайжруулах ажлууд зохион байгуулдаг талаар тайланд тодорхой тусгасан байна.
- Эмнэлгийн үйлчилгээний цар хүрээ 2016-2017 хичээлийн жилд буурсан төлөвтэй. Сүүлийн 2 хичээлийн жил чанарын судалгаа хийгээгүй тухай дурдаад шийдвэрлэх арга замаа тодорхойлжээ.
- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн талаар сургалт хийгдэж олон тооны мэргэжлийн клуб ажиллаж байна.
  - Спортын клубүүд: “ШУТИС-н Мэргэн” шагайн харваа
  - Урлагийн клубүүд: Дуу болон бүжгийн
  - Гадаад хэлний клубүүд: Орос, Япон, Англи
  - Багшийн туслах клуб: Математик, Физик, Хими, Магадлалын онол
  - Мэтгэлцээний клуб: Empowerment
  - Хэв журам сахилгын клуб: Соёмбо
- ШУТИС-ийн хэмжээнд Оюутны соёл үйлчилгээний алба бүрэлдэхүүн сургуулиуд хамтран нэг хичээлийн жилд дунджаар бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн талаарх сургалтыг 10 удаа явуулдаг байна. Үүнд
  - Эрүүл мэнд зөв хооллолт;
  - Бие хүний төлөвшил, харилцааны асуудал;
  - Хотын соёл, нийгмийн оролцоо, оюутны хөгжил;
  - Эдийн засаг, бизнесийн санаа, төслүүд, бизнес эрхлэгчдийн туршлага лекц;
  - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх.
- Хичээлийн видео бичлэгийг интернетэд байрлуулдаг нь бүх нийтийн хүртээл болгож буй сайн жишээ байна.
- БУХС дээр “Эрдмийн индэр”, “Martin’s клуб”, “FISS клуб”-ийн үйл ажиллагаа тогтмолжин улсын хэмжээний мэргэжлийн уралдаан тэмцээнд амжилттай оролцдог.
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлэх ажил хангалттай түвшинд хийгдэж байна. Тайлангийн хүснэгт 4.2.9-д олон улс, улс, бүс, их дээд сургууль, ШУТИС болон дүрэлдэхүүн сургуулиудын дунд явагддаг:
  - Эрдэм шинжилгээ;
  - Мэргэжлийн;
  - Техник, технологи;

- Спорт, урлагийн тэмцээнд амжилт гаргасанд кредитийн урамшуулал олгох тухай харуулсан.
- Мөн хүснэгт 4.2.10-т:
  - Олон нийтийн оролцоог дэмжих
  - Сурлагын амжилтыг дэмжих
  - Оюутны холбооны үйл ажиллагааг дэмжих чиглэлээр олгох кредитийн урамшууллыг харуулсан байна.
- Сүүлийн дөрвөн жилд сургалтын амжилтаар нийт 260 оюутан захирлын нэрэмжит хуудсанд бичигдэн кредитийн урамшуулал авсан бол 27 оюутан 60 кредитийн урамшуулал авсан байна.
- Сүүлийн гурван жилд 149 оюутанд 20723625 төгрөгийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт олгосон байна. Амжилт гаргасан оюутныг сургуулийн вэб хуудсаар дамжуулан алдаршуулдаг байна.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төвийн үйл ажиллагааны хүрээнд:
  - Оюутныг ажлын байранд бэлтгэх
  - Төгсөгчдийг ажлын байртай болгох, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх
  - Цагийн болон байнгын ажлын байранд зуучлах
  - Оюутныг хөдөлмөрийн зах зээлийн мэдээ, мэдээллээр хангах сургалтууд явагддаг байна.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийн вэб хуудас ажилладаг ба сургуулийн оюутны соёл үйлчилгээний алба дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:
  - Тэтгэлэг олгогчдын нээлттэй өдөрлөг;
  - Оюутны хөдөлмөр эрхлэлт ба цагийн ажил өдөрлөг;
  - Төгсөгч ба ажлын байр;
  - Ажлын байрны чиг хандлага;
  - Гадаадын улс оронд магистрын сургалтад тэтгэлэгтэй суралцах боломж;
  - Ажилд орох, ярилцлагад бэлдэх, ажлын байранд өөрийн имижийг хэрхэн өсгөх;
  - Ажлын байрны үзэсгэлэн яармаг.
- ШУТИС-н ажилд зуучлагдсан оюутны тоо захиалгаас давсан байгаа боловч 40 гаруй хувь нь цагийн ажилд орсон байна.
- Суралцагчийн эрдэм, шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулж хэвшсэн нь дараах ажлуудаас харагдаж байна.
  - Монгол улсын ерөнхийлөгч П. Очирбатын нэрэмжит “Эрдмийн чуулган”;
  - “Эрдмийн шувуу” эрдмийн чуулган жил бүр зохион байгуулагддаг ба эдгээрт Хүмүүнлэгийн ухаан, Эдийн засаг, Менежментийн салбар хуралдаанд оролцон эмхэтгэл хэвлүүлдэг байна.
- БУ-ын мэргэжлийн уралдаан тэмцээн болох:
  - “Өчигдөр, Өнөөдөр, Маргааш” Маркетингийн менежмент мэргэжлийн өдөрлөг;
  - Санхүүгийн менежмент мэргэжил сурталчлах өдөрлөг;
  - Мэдээллийн системийн менежмент мэргэжлийн өдөрлөг;
  - Менежментийн улсын олимпиад;
  - Хүний нөөцийн менежмент улсын олимпиад;
  - Экономиксийн улсын олимпиад;
  - Маркетингийн улсын олимпиад;
  - Ажил хэрэгч тоглоом;
  - Эдийн засгийн форум;
  - Эврика залуу багш, оюутны эрдэм шинжилгээний их хурал;
  - Мэдлэгийн эдийн засаг ба хөгжлийн менежментийн шинэ хандлага;

- Бусад сургуулиудтай хамтарсан сургалт семинаруудад тогтмол амжилттай оролцдог.
- БУХС-иас зохион байгуулдаг “Эрдмийн шувуу”, “Технологийн менежмент өнөө ба ирээдүй”, “Мэдлэгийн эдийн засаг ба хөгжлийн менежментийн шинэ хандлага”, Нийгмийн удирдлагын бакалавр оюутны эрдэм шинжилгээний хурлуудыг сүүлийн 3 жил тогтмол зохион байгуулан амжилттай оролцсон оюутныг урамшуулсан байна.
- Улсын хэмжээнд явагддаг олимпиадад идэвхтэй оролцдог ба хамрагдаж буй оюутны тоо өссөн байна. Харин бусад үйл ажиллагаа буурч хамрагдаж буй оюутны тоо ч буурсан байна.
- ШУТИС дээр оюутны соёл үйлчилгээний алба, Сэтгэл зүйн төв ажилладаг шилдэг туршлага байна.
- Хичээлийн видео бичлэгийг интернетэд байрлуулдаг нь бүх нийтийн хүртээл болгож буй сайн жишээ байна.

#### **Анхаарах асуудал:**

- Шилдэг элсэгч оюутны ЕШ-ийн оноо 2013 онд 780 байсан бол 2017 онд 647 болтол буурсан;
- Зөвлөх багшаас бусад ажлын байруудын тухайд урамшуулал, идэвхжүүлэлтийн талаар тодорхой нотлох баримт байхгүй;
- Судалгааны асуулга хэт ерөнхий, Цөөн асуулттай нь тухайн чиглэл тус бүрийг бодитой шинжлэхэд учир дутагдалтай. Асуулгын нээлттэй асуултын хариултыг нэгтгэн цаашдын үйл ажиллагаандаа тусгах талаар санал боловсруулсан зүйл хомс;
- Сэтгэл зүйн төв, фитнес зэргийн ажиллагаа тогтмол бус, байрны тохижилт, техник хэрэгсэл хуучирсан орчны соёл хангалтгүй;
- Оюутны байр, сэтгэл зүйн төв, фитнесийн байр зэрэгт хөрөнгө оруулалт хийсэн талаарх мэдээлэл тайланд тусгагдаагүй;
- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн чиглэлийн сургалт буурах хандлагатай;
- Сургалтын талаарх сүүлийн жилүүдийн мэдээлэл вэб хуудсанд тавигдаагүй;
- Зохион байгуулж буй ажлын үр дүнг нэгтгэн дүгнэсэн талаарх мэдээлэл байхгүй;
- Кредитийн хөнгөлөлт урамшуулалд хамрагдах оюутны тоо буурах хандлагатай;
- Хөдөлмөрийн биржийн ажлын төлөвлөгөө тодорхойгүй, ажил цаг үеийн байдалтай явагдаж байх магадлалтай;
- Тайланд тусгагдсан ажлуудын дийлэнх нь ШУТИС-аас зохион байгуулагдсан;
- Сүүлийн жилүүдэд зохион байгуулагдаж ажлын тоо нэр төрөл буурах хандлагатай;
- Мэргэжлийн уралдаан тэмцээнүүдийн тоо тэдгээрт оролцох оюутны тоо буурсан зэргийг анхаарах хэрэгтэй.

#### **Зөвлөмж:**

1. ШУТИС-н оюутны соёл үйлчилгээний албаны чиг үүргийг хэрэгжилтийг хангах чиглэлийн албан ёсны орон тоо тус салбар сургууль дээр бий болгох;
2. Судалгааны асуулгыг тухайн ажлыг сайжруулах чиглэлд боловсруулан түүний мөрөөр ажил зохион байгуулсан тухай тодорхой тайлагнадаг;
3. Оюутны байр, сэтгэл зүйн төв, фитнес зэргийн ажиллагааг тогтмолжуулж үр дүнг нь судлан сайжруулах төлөвлөгөөтэй ажиллах;
4. Оюутны байр, сэтгэл зүйн төв, фитнес, их эмчийн төвд жил бүр хөрөнгө оруулалт хийх талаар санаачилгатай ажиллах;
5. Нэг хичээлийн жилд зохион байгуулах бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн талаарх сургалтын талаар оюутнуудаас санал аван хийх ажлын тоо, нэр төрөл, хамрах хүрээг өргөжүүлэх;
6. Кредитийн хөнгөлөлт урамшуулалтай зэрэгцүүлээд өөр аргуудыг өргөн хүрээнд хэрэглэх ажлыг үүсгэл санаачилгад тулгуурлан хийх;

7. Оюутныг өргөн хүрээнд хамруулах ажлыг зохион байгуулах ба ялангуяа сургалтын хоцрогдолтой, ёс зүй, сахилгын доголдолтой оюутанд зориулсан тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг ажлууд болно.

#### **4.3 Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг**

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

##### **Үзүүлэлт нотолгоо:**

- Оюутны сайн дурын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дэмжсэн байдал
- Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилттэй байх, зориулалтын дагуу зарцуулдаг байдаг
- Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнадаг байдал

##### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутны зөвлөл нь бүтэц зохион байгуулалтын хувьд Дотоод үйл ажиллагаа зохицуулалт, Гадаад харилцаа хамтын ажиллагаа, Эрдэм шинжилгээ технологи, Соёл хүмүүжил, Мэдээлэл сурталчилгаа тус бүрийг хариуцсан алба нэгжүүдтэй ажиллаж байна.
- Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубийн үйл ажиллагааг дэмжих санхүүжилтийг сургуулиас тусгайлан заасан журмын дагуу олгодог. Оюутны тооноос хамааран жил бүрийн төсвийг тооцдог гэх ба түүний биелэлт ямар түвшинд байгааг тодорхой тогтоох боломжгүй байна.
- Сүүлийн гурван жилийн байдлаар нийт зардал буурсан төлөвтэй байгаа боловч энэ нь нийт оюутны тоо буурсантай холбоотой ба нэг оюутанд ноогдох зардал тогтвортой байна. Оюутны үйл ажиллагааны зардлын бүтэц нь эрдэм шинжилгээ, спорт урлаг, магистр доктор, оюутны арга хэмжээний зардал, тэтгэлэг, хөнгөлөлт, унааны зардал зэргээс бүрдэж байна.
- Сүүлийн гурван жилийн оюутны үйл ажиллагааны зардлын бүтцийг шинжлэхэд дараах төлөвтэй байна. Зардлын бүтцийг нийт зардалд үзүүлэлт тус бүрийн эзлэх хувийн жинг тодорхойлбол 2014 онд эрдэм шинжилгээнд зарцуулах зардал бага дөнгөж 5%, магистр доктор, оюутны арга хэмжээний зардал 2%, тэтгэлэг, хөнгөлөлт 35%, спорт урлаг 19%, унааны зардал 39% байсан бол 2016 онд эрдэм шинжилгээнд зарцуулах зардал 10%, магистр доктор, оюутны арга хэмжээний зардал 11%, тэтгэлэг, хөнгөлөлт 42%, спорт урлаг 16%, унааны зардал 21% болсон байна. Оюутны үйл ажиллагааны зардалд эрдэм шинжилгээ, тэтгэлэг хөнгөлөлтийн зардал өсөж, спорт урлаг арга хэмжээний зардал буурч байна.
- Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтыг ангийн дарга нараар дамжуулан тайлагнадаг. Өөр аргуудыг ашиглахаар санал боловсруулсан байна.

##### **Анхаарах асуудал:**

- Байгууллагын удирдлагад оюутны зөвлөл хэрхэн оролцож асуудлаа шийдвэрлүүлэх боломжоор хангах;
- Төсвийн зарцуулалтын талаарх мэдээлэл дутагдалтай тул үнэлэх боломжгүй;
- Оюутны зөвлөлийн ажил хариуцдаг ажилтан хичээл сургуулиас хоцордог асуудлыг шийдвэрлэх;
- Оюутнуудын дунд тус байгууллагын нэр хүнд тааруу байгааг;
- Оюутны үйлчилгээний зардал сүүлийн гурван жил дараалан буурсан
- Зардалд магистр, докторын оюутантай холбоотой зардлууд тусгагдсан байгаа зэргийг анхаарах шаардлагатай.

### **Зөвлөмж:**

1. Оюутны байгууллагын үйл ажиллагааг дэмжих чиглэлд сургуулийн удирдлагаас санаачилгатай ажиллах;
2. Оюутны байгууллагын үйл ажиллагаанд чанарын үнэлгээ хийн сайжруулах ажил хийх;
3. Оюутны байгууллагын удирдлагыг томилдог байдлыг үүсгэл санаачилгад тулгуурлан шийдвэрлэх;
4. Үйл ажиллагааны нэр төрлийг өргөжүүлэн нийт оюутнуудад хүртээмжтэй болгох;
5. Төсөв хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг байнга тайлагнадаг байх ажлуудыг хийх нь ажлын үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.

### **4.4 Суралцагчийн урамшууллын тогтолцоо**

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Урамшуулал, тэтгэлэгхөнгөлөлтөдхамрагдсансуралцагчдынтоо
- Суралцагчдынүзүүлсэнамжилтууд
- Сургуулиас үзүүлж буй урамшуулал, дэмжлэг

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын төрийн сангийн тэтгэлэгт хамрагдсаныг сүүлийн 5 жилээр нэгтгэвэл
  - Буцалтгүй тусламжид 517 оюутан хамрагдан 833.2 сая төгрөг;
  - Хөнгөлөлттэй зээлд 102 оюутан хамрагдан 52.1 сая төгрөг;
  - ТАХ-н зардлаар суралцагч 493 оюутанд 52.1 сая төгрөг тус тус зарцуулсан байна.
- Тайлангаар тэтгэлэгт хамрагдалтын хүрээ хумигдсан, буцалтгүй тусламжаар суралцагсдын тоо 2012 оныхоос 2.2 дахин өссөн атал нэг оюутанд ноогдох зардал 1.5 дахин өссөн, ТАХ зардлаар суралцах оюутны хамрагдалт буурсан нийгмийн эмзэг бүлгийн хамрагдалт байхгүй байна.
- Үндэсний болон урамшууллын тэтгэлэгт сүүлийн 5 жилд нийт 7608 оюутанд 3.319 сая төгрөг зарцуулснаас:
  - 50 хувийн урамшууллын тэтгэлэгт 633 оюутан 188.4 сая төгрөг;
  - 75 хувийн урамшууллын тэтгэлэгт 528 оюутан 231.1 сая төгрөг;
  - 100 хувийн урамшууллын тэтгэлэгт 1 оюутан 0.7 сая төгрөг авсан байна.
- Замын зардал нөхөн олголт сүүлийн 5 жилд 824 оюутанд 68.3 сая төгрөг
- Нийтийн тээврийн хөнгөлөлт сүүлийн 5 жилд 2618 оюутанд
- Оюутны эрүүл мэндийн даатгалд 6325 оюутан тус тус хамрагдсан байна.
- Суралцагчид улсын чанартай олимпиад уралдаан тэмцээнд жилд бүр амжилттай оролцож буй талаар тайланд тодорхой тусгасан байна.
- Суралцагчдын үзүүлсэн амжилттай хангалттай сайн байна.
- ШУТИС-иас дараах тэтгэлэг урамшуулал олгож байна.
  - ШУТИС-н ректорын нэрэмжит тэтгэлэг,
  - Кредитийн урамшуулал олгож байна
  - “Тоёота ШУТИС” сургалтын сангийн тэтгэлэг
- БУХС-ийн Бизнесийн удирдлагын салбарын оюутнуудад 2015-2016, 2016-2017 оны хичээлийн жилүүдэд 13 нэр төрлийн тэтгэлэгт 65 оюутан хамрагдан 15.1 сая төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн байна.
- Сүүлийн 5 хичээлийн жилд
  - Шагнал урамшуулалд 481 оюутан
  - Захирлын нэрэмжит хуудсанд 439 оюутан бичигдэн 4669.8 сая төгрөгийн
  - Сургуулиас оюутанд олгох кредитийн урамшуулалд 455 оюутанд

- Шилдэг тэргүүний оюутны шагнал 493 оюутан 57454 мянган төгрөг тус тус олгосон байна.

- Олон тэтгэлэг хөтөлбөрүүдэд оюутнуудыг хамруулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Тайлангаар тэтгэлэгт хамрагдалтын хүрээ хумигдсан;
- Буцалтгүй тусламжаар суралцагсдын тоо 2012 оныхоос 2.2 дахин өссөн атал нэг оюутанд ноогдох зардал 1.5 дахин өссөн;
- ТАХ зардлаар суралцах оюутны хамрагдалт буурсан;
- Нийгмийн эмзэг бүлгийн хамрагдалт хангалтгүй;
- Тэтгэлэг, урамшууллын нэр төрөл сүүлийн жилүүдэд буурсан;
- Тэтгэлэг урамшуулалд хамрагдах оюутны тоо буурсан байна.

#### **Зөвлөмж:**

1. Үндэсний хөнгөлөлт урамшуулалд хамрагдах ёстой оюутны судалгааг гарган хамрагдалт хэдэн хувьтай байгааг нарийвчлан тооцож дараагийн зорилтуудыг дэвшүүлэх;
2. Суралцагчдын гаргасан амжилтад сургалтын үзүүлэлт болон гадаадын нэр хүндтэй сургуульд боловсролын зэргээ ахиулахаар суралцсан талаар тусгах;
3. Сургуулиас олгож буй тэтгэлгийг нийгмийн эмзэг бүлэг болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгож буй талаарх ажлыг сайжруулах шаардлагатай.

#### **4.5 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал
- Шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлт
- Шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, суралцагчийн эрх ашгийг дээдэлсэн байдал

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Шилжилт хөдөлгөөний асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэдэг байна. Шилжилт хөдөлгөөний байдлыг авч үзвэл:
  - 2014- 2018 онуудад 312 оюутан шилжин ирсний 132 оюутан сургууль дотроо мэргэжил хооронд, 132 оюутан бүрэлдэхүүн сургуулиас, 48 оюутан бусад сургуулиа шилжин ирсэн.
  - Мөн онуудад 263 оюутан шилжин явснаас 52 оюутан сургууль дотроо мэргэжил хооронд, 123 оюутан бүрэлдэхүүн сургуулиас, 87 оюутан чөлөө авсан байна.
- Шилжин явсан 125 оюутнуудын 32 нь хувийн, 18 нь өөр сургуульд, 3 нь бүрэлдэхүүн сургуульд шилжсэн, 23 нь ар гэрийн гачигдлаар, 26 нь гадаадад суралцах, 19 нь эрүүл мэндийн байдлаас шалтгаантай байна.
- Шилжин ирэгсдийн талаар судалгаа мэдээлэл хангалттай. Шилжин явагсдын шалтгааныг нарийвчлан боловсруулж дүгнэлт хийн тайланд тусгасан байна.
- ШУТИС-н ректорын зөвлөлийн 2011 оны 6-р сарын 15-ны өдрийн журмаар шилжилт хөдөлгөөнийг зохицуулдаг ба тус журмыг сургуулийн вэб хуудсанд байрлуулсан байна. Суралцах гэрээ цуцалсан, чөлөө авсан оюутны тоо өссөн байна. Эрх зүйн зохицуулалт хангалттай хийгдсэн. Энэ журмаар дараах харилцааг зохицуулж байна. Үүнд
  - Оюутны шилжүүлэн сургах үйл ажиллагааг;
  - Хичээл дүйцүүлэн тооцох;
  - Кредит дүйцүүлэн тооцох;

- Дипломын дараах сургалтын хөтөлбөрийг харьцуулан оюутан элсүүлэх;
  - Чөлөө олгох, үргэлжлүүлэн сургах;
  - Төлбөр тооцоог хамруулдаг байна.
- Тус журам нь шилжин суралцахыг хүсэгчид сургуулийн элсэлтийн бодлогыг хангаж буй тохиолдолд шилжин суралцах боломжоор хангасан гэж үзэж болохоор байна.

**4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **ШАЛГУУР 5. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

### **5.1 Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого: тушаал, урамшууллын бодлого сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин
- Багш суралцагчдын тооны зохистой харьцаа
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал
- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- ШУТИС-ийн ...“олон улсад нэр хүнд бүхий, судалгаанд суурилсан, нээлттэй их сургууль болох” алсын хараа, ... “мэргэжлийн өндөр мэдлэг, дадал, чадавхитай, бүтээлч сэтгэлгээтэй мэргэжилтэн судлаачдыг бэлтгэх” эрхэм зорилго, ... БУХС-ийн “бизнесийн удирдлага, менежмент, хүмүүнлэгийн чиглэлээр өрсөлдөх чадвартай, мэргэжилтэн судлаачдыг бэлтгэх” зорилгын хүрээнд авч үзвэл БУХС-ийн бакалаврын 5 хөтөлбөрт 32 багш ажиллаж байгаагийн 23 хувь нь (8 багш), докторын зэрэгтэй, энэ нь 2014-2015 оны хичээлийн жилээс 9.7 хувиар буурсан, 5 хөтөлбөрийн 4 нь 1-3 докторын зэрэгтэй багштай, 1 хөтөлбөр доктор зэрэгтэй багш байхгүй, (ХМИТ 2 хуудас 211) байна. Гэхдээ нийт багшийн 60.6 % нь 10-аас дээш ажилласан, магистр зэрэгтэй 24 багшийн 50 хувь нь ахлах багшийн орон тоонд ажилладаг, багшийг сонгон шалгаруулах журам, хөгжүүлэх цогц төлөвлөгөөтэй, “багш нараа хөгжүүлэх, мэргэшүүлэх” чиглэлийг баримталдаг, 2018-2019 онд 7 багш докторын зэрэг хамгаалж, докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь 40.6 хувьд (ХМИТ 2, хуудас 203, 208) хүргэхээр төлөвлөж байгаа нь докторын зэрэгтэй багшийн тоо нэмэгдэх үндэслэлтэй боломж хэмээн үзэхээр байна.
- “ШУТИС-2021 Мастер төлөвлөгөө”-ний Стратегийн зорилтын 4.3-д “Сургуулийн хүний нөөцийн бодлогыг шинэчлэх, хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх”, 4.4-д “Гадаад, дотоодын чадварлаг мэргэжилтнүүдийг судалгаа, сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулах замаар хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх” зорилтын хүрээнд чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, багшийг сонгон шалгаруулах, хөгжүүлэх, төлөвлөх асуудлыг 50 орчим дүрэм журмуудаар (ХМИТ 2, хуудас 201) зохицуулж байна.
- “Бизнесийн удирдлага” багц хөтөлбөрийн хувьд сүүлийн 3 жилд 2 багш шинээр сонгон шалгаруулж, хүний нөөцийг, багшийг хөгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж,

2015 оноос “Багш хөгжлийн төв”-ийг байгуулж, 6 багш докторын зэрэг хамгаалж, дотоодод 84 багш, гадаадад 22 багш (давхардсан тоогоор) урт, богино хугацааны сургалтад хамрагдаж мэргэжил дээшлүүлж, 2014 оны аттестатчиллын дүнд 11 багш зэрэглэл ахисан байна.

- Түүнчлэн ШУТИС-ийн дүрэм, “ШУТИС-ийн профессор багш ажилтан, ажилчдыг шагнаж урамшуулах журам”-ын дагуу үр дүнгийн урамшуулал, шагналд нэр дэвшүүлэх, гадаад мэргэжил дээшлүүлэх, шалгарсан тохиолдолд шилдэг багшийн урамшуулал олгох, тодорхой хугацааны сургалтын зардлыг хариуцах зэрэг хэлбэрүүдээр сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагааны үр дүнг урамшуулж байна. Багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд нийгмийн халамж, үйлчилгээний хувьд бодитой дэмжлэг, туслалцаа үзүүлэх (хуудас 213) ажлыг сайжруулах хэрэгтэй гэсэн тус хөтөлбөрийн дүгнэлтийг дэмжиж байна.
- ШУТИС-ийн хэмжээнд хүний нөөцийн бодлогын үндсэн баримт бичгүүд бүрэн боловсруулагдаж, эрх зүйн талаас багшийг хөгжүүлэх, урамшуулах боломж бүрдсэн байна.
- Бизнесийн удирдлагын багц хөтөлбөр нь 100 хувь үндсэн багштай, нийт багшийн 60.6 хувь нь 10-аас дээш ажилласан туршлагатай, магистр зэрэгтэй 24 багшийн 50 хувь нь ахлах багшийн орон тоонд ажилладаг, заах арга зүйн зохих ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### **Зөвлөмж:**

1. Эрдмийн зэрэг цолтой багшийн тоо, эзлэх хувийг нэмэгдүүлэх
2. Гадаад, дотоодын чадварлаг мэргэжилтнүүдийг судалгаа, сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулах ШУТИС-ийн стратегийн зорилтыг хэрэгжүүлэх

#### **5.2 Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Багшийн мэргэжил; заах арга зүйн ур чадвар; эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин; суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байдал
- Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт
- Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал
- Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдал

#### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- 2015 онд байгуулсан “Багшийн хөгжлийн төв”-өөс багшийг хөгжүүлэх 4 эх үүсвэрийн судалгаа буюу гадаад хэлний мэдлэг, заах арга, ур чадварыг хөгжүүлэх, хувь хүний хөгжил, мэргэшүүлэх сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйг сайжруулах сургалтын хэрэгцээг тодорхойлж, 2 жилийн хугацаанд 5 чиглэлээр давхардсан тоогоор 45 сургалт, ажил зохион байгуулсан, профессор багш нарын 90 хувь дотоодод, 10.7-23 хувь нь гадаад мэргэжил дээшлүүлсэн зэрэг нь багшийг хөгжүүлэх талаар төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлсэн сайн тал байна.
- Багш нарын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас үзэхэд тус төвөөс хэрэгжүүлж буй сургалтуудаас сүүлийн жилд зохион байгуулсан гадаад хэлний сургалт, багш нарын туршлага солилцох уулзалт, сургалтууд (“Пүда” багшийн хичээлз эрэг) нэлээд үр дүнтэй байдаг талаар дурдаж байлаа.
- Сургалтын үр дүнд багш нарын мэдлэг, ур чадвар дээшилсэн, хэвлэж, нийтлүүлсэн гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл нэмэгдсэн зэргээр (ХМИТ 2, хуудас 221, Хүснэгт 5.2.5) сайн үр дүнгүүд байгаа боловч 2016-2017 оны

хичээлийн жилд 2014 оныхоос багшийн хөгжил, чадавхи талаас нь өмнөх жилүүдээс хэрхэн ахисан, туршлага, үлгэр болохуйцаар хөгжиж, дээшилсэн үр дүн, үр өгөөжийн талаар дүн шинжилгээ хийгээгүй (2018.05.03-нд нэмж ирүүлсэн материалд тайлан, хавсралтад байгаа үр дүнг оноор задлан тоочин тайлбарласан байна.), багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ур чадварыг сайжруулах талаар SWOT шинжилгээний хэсэгт гурван асуудлыг (ХМИТ 2, хуудас 248) анхаарах тухай дурдсан боловч төлөвлөгөөнд тодорхой тусгаагүй байна. (хүснэгт 5.1.4.)

- Тус хөтөлбөрийн тайлан, багш нартай хийсэн ярилцлагаас үзэхэд багшийг хөгжүүлэх ерөнхий хэрэгцээний судалгаанд тулгуурласан төлөвлөгөө боловсруулж, түүнийг сайн хэрэгжүүлдэг боловч мэргэжлийн мэдлэг, ур чадвар, заах арга зүй, эрдэм шинжилгээний ажлын ур чадварыг нэмэгдүүлэх, ахлах багш нарыг докторын зэрэг хамгаалуулахад төвлөрсөн, “судалгааны их сургууль болох” зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн багш бүртэй ажиллах тогтвортой хэрэгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөр дутагдалтай байна
- Салбар сургуулийн түвшинд “Багшийн хөгжлийн төв” байгуулсан, тус төв нь хүний нөөцийн бодлоготой уялдуулан “PDCA” төлөвлөлтийн загвараар, багшийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллаж эхэлсэн нь “...сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөц бүрдүүлэх” шалгуурыг хангах, багшийг хөгжүүлэх, урамшуулах, тогтвортой ажиллуулах онцгой давуу тал байна.
- “Багшийн хөгжлийн төв”-өөс “гадаад хэлний мэдлэг, заах арга, ур чадварыг хөгжүүлэх, хувь хүний хөгжил, мэргэшүүлэх сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйг сайжруулах” багшийг хөгжүүлэх сургалтын хэрэгцээний 4 эх үүсвэрийн судалгаа нь эхлэлийн шинжтэй боловч энэ судалгааг тогтмолжуулж, үр дүнг нь үнэлэх тодорхойлох хэмжүүрээ тодорхойлж, явуулсан сургалт, үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийж, багш бүрийн онцлогийг харгалзан хөгжүүлэх боломж, багшийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх ажлын эхлэл болох сайн туршлага байна

#### **Зөвлөмж:**

1. Багш бүрийн мэргэжил, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн “Багш хөгжлийн хөтөлбөр” (3-5 жилийн) хэрэгжүүлэх
2. “Багшийн хөгжил төв”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж, багшийн ур чадварыг төлөвлөгөөтэй, үе шаттай хөгжүүлдэг, багшийн хөгжлийн загвар/жишиг төв болох

### **5.3 Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо
- Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал
- Судалгааны ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй; судалгааны ажил шинэчлэгдэн хөгжсөн байдал
- Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал

#### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Бизнесийн удирдлага багц хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн тайланд тус хөтөлбөрийн үндсэн 32 багшийн “инноваци, патент, зохиогчийн эрх, ном сурах

бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл” зэрэг эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэд хөтөлбөрүүдээр, багш бүрээр, нэр төрлөөр, он, оноор хураангуй болон дэлгэрэнгүй байдлаар харуулж, үйл ажиллагааны үр дүн, өгөөжийг сайжруулах харьцуулалт, шинжилгээ, үнэлгээ хийж тусгаагүй тул тайланд тусгасан үр дүнгийн хэмжээнд тус шалгуурыг дүгнэх боломж байна.

- Бизнесийн удирдлага багц хөтөлбөрийн тайланд тусгасан, дурдсан хэмжээнд дараах үр дүнгүүд байна. Үүнд:
  - Бизнесийн удирдлага хөтөлбөрийн профессор багш нар 2015-2017 онд 7 ном сурах бичиг, 9 гарын авлага (нийт 16) туурвисан бөгөөд он дарааллаар авч үзвэл 2015 онд 9, 2016 онд 4, 2017 онд 1 сурах бичиг (хуудас 225, Хүснэгт 5.3.1.) тус тус бичсэн байна. Түүнчлэн 2015 онд 3, 2016 онд 5, 2017 онд 1 ном, гарын авлагад, нийт 9 бүтээлд зохиогчийн эрх авчээ.
  - Профессор багш нар 2014-2017 онд 16 төсөл, гэрээт ажилгүйцэтгэсэн нь нэг хөтөлбөрт жилд дунджаар нэг төсөл, гэрээт ажил ногдож байна. 2014 онд 2 төсөл, нэг гэрээт ажилд 9 багш оролцож байсан бол 2017 онд нэг төсөл, 6 гэрээт ажилд 6 багш оролцсон нь сүүлийн жилд төсөл, гэрээт ажлын тоо нэмэгдсэн боловч багш нарын 17.0-18.8 хувь нь төсөл, гэрээт ажилд оролцож байна.
  - Судалгааны ажлын үр дүнгээр PM204, HR 306, BA326зэрэг 3 хичээлийн агуулга, хөтөлбөрийг шинэчилж, 2 гарын авлага сургалтад ашиглаж байгаа, багш, оюутнууд судалгааны арга зүй эзэмшсэн үр дүнтэйг хүснэгт 5.3.3-д харуулжээ.
  - Багц хөтөлбөрийн 30 багшийн 107 эрдэм шинжилгээ, судалгааны өгүүллийг багшийн нэрээр жагсаасан (хуудас 231-235, хүснэгт 5.3.б), ахиц дэвшил, үр дүн, өгөөжийг сайжруулах харьцуулалт, шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна. Эшлэгдсэн байдлын тухай болон 2014 оноос хойш ямар ахиц, дэвшил, томоохон үр дүн, үр нөлөөний тухай хөтөлбөрийн зүгээс өөрийн үнэлгээ байхгүй байна.
- Бизнесийн ахисан түвшингийн сургалтад шилжсэн боловч бакалаврын түвшний сургалтад оролцдог, Монгол улсын боловсролын болон менежмент, санхүү зэрэг тухайн салбартаа нэр хүндтэй, гол ном сурах бичиг туурвидаг, тухайн сургуулийн сургалт, эрдэм судлалын үнэ цэн, өв, соёлыг тээж буй эрдэмтэд судлаачид тус сургуульд ажиллаж байна.

#### **Зөвлөмж:**

1. Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны үр чадварыг ахиулах талаар “Багшийн хөгжлийн төв”-ийн PDCA төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх
2. Багш хөгжлийн төв нь мэргэжлийн болон боловсролын салбарт хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүндтэй, ахмад эрдэмтэд, судлаачдын сургалт, эрдэм судлалын их үнэ цэнэ, өв соёлыг уламжлан авч үлдэх, багш нар тэднээс суралцан хөгжих талаар төлөвлөгөө, хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх
3. Ахлах багш, багшийн эрдэм шинжилгээний өгүүлэл бичих үр чадварыг ахиулах, олон улсын нэр хүндтэй сэтгүүлд хэвлэн нийтлүүлэх өгүүллийн тоог нэмэгдүүлэх

#### **5.4 Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн хөндлөнгийн үнэлгээ /Аттестатчлал, эрэмблэлт, чансаа тогтоолт/
- Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа

- Тайлан, судалгааг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал
- Сургалтад оролцогчдоор багшийг үнэлүүлэх
- Багшийн бүхий л үйл ажиллагааны баримт, материал

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Бизнесийн удирдлага хөтөлбөрийн профессор багш нар сургалт-А, эрдэм шинжилгээ, инноваци- Б цаг, сургууль олон нийтийн үйлчилгээ-В цаг гэсэн 3 үндсэн бүтцээр өөрийн үнэлгээний тайланг бичдэг нь сургуулийн тогтмол гүйцэтгэдэг үйл ажиллагаа байна. 2016-2017 оны хичээлийн жилээс сургуулийн цахим хуудсаар ӨҮТ-г оруулдаг болсон нь багш өөрийгөө хөгжүүлж буй түвшин, анхаарах зүйлүүд, цаашдын төлөвлөгөөний чиглэлийг харах боломжтой болжээ.
- Багшийн аттестатчлал нь дэд профессор, салбар/тэнхим, салбар комисс, төв комисс 4 үйл явцтай байна. Аттестатчлалын дүнгээр “TOP 100” багшийг шалгаруулдаг бөгөөд 2014 онд БУ-ын хөтөлбөрөөс 9 багш шалгарсан байна. Багш нар “шилдэг багш” шалгаруулах уралдаанд оролцож, ажлаа үнэлүүлэх, өөрийгөө хөгжүүлэх боломжтой байна. (хуудас 240, хүснэгт 5.4.5)
- Бизнесийн удирдлага хөтөлбөр нь сургалтын төлөвлөгөөний БУСТА загвар боловсруулж, хөтөлбөрийн зорилго, зорилт, эзэмших ур чадварыг уялдуулан тодорхойлсон, хөтөлбөрийн багш нарын сургалтад өргөн ашигладаг 14 аргуудыг дурдсан зэрэг нь хөтөлбөрийг шинэчлэлийн харуулж буй боловч эдгээр загварын болон сургалтын аргын үр дүн, үр нөлөөний талаар өөрийн үнэлгээг дурдаагүй байна.
- Эрдэм шинжилгээ, судалгааны болон оюутанд чиглэсэн үйл ажиллагааны тайлан, оролцогч талуудийн сэтгэл ханамжийн судалгаа зэргийг салбарын удирдлага, оюутны холбоогоор үнэлүүлэн хэлэлцдэг тухай Хүснэгт 5.4.7-д нэгтгэн харуулсан байна. Дүгнэлт, үнэлгээнд үндэслэн сайжруулах чиглэл, үйл ажиллагааг төлөвлөгөөнд хэрхэн тусгадаг тухай мэдээлэл байхгүй байна.
- Багш нарын заах арга зүйг улирал бүрийн төгсгөлд 2 бүлэг 11 асуултаар оюутнаас судалгаа авч үнэлүүлдэг уламжлал тогтжээ. 2016-2017 оны хичээлийн жилээс эхлэн 2 бүлэг 9 асуултаар UNIMIS системээр дамжуулан судалгаа авч, үр дүн нь багшийн цахим хуудас руу шууд илгээгддэг нь багш нар өөрийн заах арга, ур чадварыг сайжруулах боломж олгож байна.

### **5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **ШАЛГУУР 6. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### **6.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ байгууллагын харьцуулсан шинжилгээ
- Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдал
- Суралцагч хичээл, багшийг сонгон суралцдаг байдал чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

- Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан байдал
- Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг хамтран хэрэгжүүлдэг байдал
- Зайны болон цахим хичээлүүдийг E-контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан байдал
- Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтынхөтөлбөрийн дагуу оюутан суралцах хугацааны 4 жилийн хуваарийг гаргаж хичээл, багшийг сонгон суралцах боломжтой бөгөөд цахим сонголтын системийг бүрэн нэвтрүүлсэн.
- UNILMS, Moodle сургалтын удирдлагын системүүдийг хослуулан ашиглаж давуу талуудыг нь хөгжүүлж байгаа нь бусад их, дээд сургуулиудын цахим сургалтын чиг баримжааг тогтоож өгөх давуу талтай.
- Цахим хичээлүүдийг бэлтгэх техник, технологи, арга зүйн нэгдсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байдал нь үлгэр жишээ болохуйц байна.
- Бизнесийн төсөл хичээлээр бусад хичээлүүдийн хүрээнд олж эзэмшсэн мэдлэг, чадваруудыг нэгтгэн бодит кейс дээр ажилладаг нь бүх мэргэжлүүдийн хувьд байгууллагыг системийн хувьд харах, практик туршлагуудыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

#### **Анхаарах асуудал:**

- Ажил олгогч, төгсөгчдийн саналд тусгагдсан англи хэлний чадвар, хувь хүний чадварыгхөгжүүлэх чиглэлээр ажлууд хэрэгжүүлж байгаа ч үр дүн нь мэдрэгдэхүйц бус байна. Жишээлбэл: Англи хэлний S.ESP310 2016 оны сургалтын төлөвлөгөөнд оруулсан боловч тухайн хичээлийн суралцахуйн үр дүн юу вэ, уг хичээлийг судлахад шаардагдах академик ерөнхий англи хэлний чадварыг эзэмшсэн эсэхийг тодорхойлсон байдал тодорхойгүй. Төгсөгчдийн уулзалтын хүрээнд суралцах хугацаанд англи хэлний мэдлэг, чадварт гарсан өөрчлөлт тодорхойгүй байдал ажиглагдсан. Мөн хувь хүний чадварыг хөгжүүлэх зорилго тодорхойлогдсон боловч тухайн хичээл судалж буй оюутанд хичээлээр хувь хүний ямар чадвар эзэмших талаар нэгдсэн мэдээлэл өгдөггүй буюу хичээлийн төлөвлөлтөд тусгадаггүй.
- Хичээл тус бүрийн агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй хэрхэн нийцэж буй талаар зураглал байхгүй, хичээл бүрийн үр дүнг нарийвчлан тодорхойлогдоогүй байна.

#### **Зөвлөмж:**

1. Хөтөлбөрийн сургалтын агуулгыг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд оролцогч талуудын оролцоог илүү тодорхой тусгах. Үүнд: Оролцогч талуудтай ямар сувгаар харилцах, ямар төрлийн мэдээллүүд авах, өгөх, тухайн мэдээллийг ямар төрлийн шинжилгээ, шийдвэр гаргалт, сайжруулалтад ашиглах тухай тогтсон процессыг албажуулах, үйл ажиллагаанд мөрдүүлэх шаардлагатай.
2. Сургалтын агуулга, арга зүй нь хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэн хэрхэн шат дараалал ахиж буйг харуулсан сургалтын төлөвлөгөөний архитектурыг гаргах. Уг архитектурт үндэслэн хичээл бүрийн төлөвлөгөө, цаг сэдвийн төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж хичээлийн хүрэх үр дүнг тодорхой тусгах, түүнийг оюутнуудад хичээл бүрийн эхэнд танилцуулж хэвших шаардлагатай байна.

### **6.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Сургалтын аргазүйг боловсруулсан баримт бичиг, загвар

- Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал
- Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, программ хангамж, техник хэрэгслийн ашиглалтын судалгаа
- Сургалтын арга зүйн судалгаа, дүгнэлт, хөгжүүлдэг байдал

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын арга зүйн олон улсын дэвшилтэд загварт суурилсан БУСТА болон СДИО загварыг хэрэгжүүлж байгаа нь тухайн сургуулийн бусад бизнесийн сургуулиудаас ялгарах онцлогийг харуулж байна.
- СДИО сургалтад багш нарыг хамруулж байгаа нь арга зүйн бодлого, хүний нөөцийг хөгжүүлэх бодлоготой уялдаж байгааг харуулж байна.
- Бизнесийн симуляци, мэргэжлийн дадлага, төгсөлтийн ажил, семинарын ажил, бие даалтын ажлуудын удирдамж, жишээнүүд нь арга зүйн төлөвлөлтийг сайн хийж байгааг харуулж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хичээл бүрийн төлөвлөлт харилцан адилгүй, UNIMIS системд оруулсан хичээлийн хөтөлбөр, цаг сэдвийн хуваарь хэтэрхий ерөнхий байна.
- Сургалтын арга зүйн материал харилцан адилгүй боловсруулалттай байна.
- Сургалтын арга зүйн шинжилгээ дүгнэлтийг хийдэг аргачлалууд хязгаарлагдмал байна.

#### **Зөвлөмж:**

1. Хичээлийн хөтөлбөрөөс гадна хичээлийн сэдэв бүрийн нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах, тухайн сэдвийн хүрээнд хүрэх үр дүн, түүнд чиглэсэн сургалтын арга зүй, технологи, үнэлгээний аргыг тодорхой тусгаж өгөх шаардлагатай байна.
2. Нэгж хичээлийн төлөвлөгөө боловсруулж, шинжилгээ хийж, хэрэгжүүлж хэвших нь сургалтын арга зүйн тасралтгүй ахиц дэвшил гаргах чухал алхам болно гэж дүгнэж байна.
3. Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, програм хангамжийг албан ёсны лицензтэй ашиглах тал дээр анхаарал хандуулах, техник хангамж, програм хангамжийн хувьд мэдээллийн технологийн урт хугацааны төлөвлөлтийг хийх шаардлагатай гэж дүгнэж байна

### **6.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлал, хэрэглээ
- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг байдал
- Суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байдал
- Суралцагчийн гаргаж буй амжилтууд

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хичээл бүрийн явцын үнэлгээг оруулдаг хугацаатай өөрчлөлт оруулж болохгүйгээр системийг зохион байгуулсан болон эцсийн үнэлгээг хөндлөнгийн үнэлгээ хэлбэрээр авч шинжилгээ хийж ажилладаг нь сайшаалтай.
- Peregrine, Eduniversal, чанарын алтан титэм зэрэг хөндлөнгийн үнэлгээг олон хэлбэрээр ашиглаж байна.

- Улсын хэмжээний олимпиадуудад амжилттай оролцож байгаа нь бизнесийн удирдлагын хөтөлбөрийн амжилтыг илэрхийлж буй үзүүлэлт юм.

#### **Анхаарах асуудал:**

- Мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлэхээс аргаас өмнө нарийн тодорхойлж анхаарах ёстой зүйл бол хичээл, сэдэв бүрийн хүрэх үр дүн юм.
- Мэдлэг, ур чадварын үнэлж байгаа боловч явцын үнэлгээ хийж дүгнэлт өгөх буюу оюутанд зориулсан үнэлгээ дутмаг, үнэлгээ нь илүү хөтөлбөр, багшийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад чиглэсэн байна.
- Хандлага төлөвшил, хувь хүний чадваруудад гарч буй өөрчлөлт ахиц дэвшлийг хэрхэн үнэлж хөгжүүлдэг эсэх нь тодорхойгүй байна.

#### **Зөвлөмж:**

1. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл, сэдэв бүрийн хүрэх үр дүн, тухайн үр дүн бүрт тохирсон үнэлгээний арга, хэлбэрийг тодорхойлох замаар оюутны хөгжлийг жигд хангах тал дээр тодорхой төлөвлөгөө гаргаж үе шаттайгаар хэрэгжүүлэх хэрэгтэй.
2. Мэдлэг, ур чадварын ахиц дэвшлийг хэрхэн үнэлж байгааг явцын үнэлгээтэй уялдуулах буюу оюутанд үр ашгийг нь хүртэх үнэлгээг тогтмолжуулж системд тусгах нь зүйтэй.
3. Хичээл бүрийн хувьд хандлага төлөвшил, хувь хүний чадваруудыг тодорхойлсон сургалтын хөтөлбөрийн нэгдсэн зураглалыг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх нь ажил олгогчийн эрэлт хэрэгцээг хангасан, насан туршийн боловсролын үзэл баримтлалд нийцсэн байдлаар хөгжихөд чухал нөлөөтэй гэж үзэж байна.

**6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **ШАЛГУУР 7. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ**

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангаж, сонирхогч талуудын эрэлтэд нийцсэн, үнэ цэнэтэй байна.

#### **7.1. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлдэг байдал
- Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацаа

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны нийцлийн судалгааг 2 жилийн давтамжтай явуулдаг байна. Ажлын байрны нийцэл 82% байгаа нь сайн боломжийн гэж үзэхээр байна.
- Төгсөгчид, ажил олгогчийн судалгааны үр дүнд үндэслэн сургалтын хөтөлбөр арга зүйд өөрчлөлт оруулж ажилладаг байна сайхан туршлага байна.
- Төгсөгчдийн сэтгэл ханамж 4,2 буюу 85%-тай байгаа нь хөтөлбөрийн үр дүн өндөр байна гэж үзэж үндэстэй.
- Төгсөгчдийн 92,5% нь 1 сараас 1 жилийн дотор байгаа нь боломжийн өндөр үзүүлэлт бөгөөд төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацаа 1-6 сар байгаа нь сайшаалтай өндөр үзүүлэлт юм.

#### **Анхаарах асуудал:**

- Ажил олгогчдын сэтгэл ханамж 3,84 буюу 76,8%-тай байгааг анхаарах хэрэгтэй гэж үзлээ.
- Ажил олгогчидтой ажиллах механизм бүрдүүлэх хэрэгтэй

#### **Зөвлөмж:**

1. Ажил олгогчидтай ажиллах албан ёсны тогтсон журам, систем, механизм бүрдүүлэх хэрэгтэй

### **7.2.Хөтөлбөрийн үр нөлөө:**

Хөтөлбөр үр дүнгээ үнэлүүлэх, үнэ цэнээ тодорхойлох, ахиц дэвшлээ харуулах нотолгоотой байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтууд
- Салбар, хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурь
- Мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр /Төрийн болон ТББ-ын зүгээс хийсэн үнэлгээ, судалгаа/

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн 64% Сайд, УИХ-ын гишүүн, захиралын албан тушаалд буюу карьер өндөр албанд 1300000-аас дээш төгрөгийн цалинтай ажил эрхэлж байгаа нь төгсөгчдийн амжилт маш сайн байна гэж үзэж үндэслэл болж байна.
- Төгсөгчид хөдөлмөрийн зах зээлийн 35,8-44,4%-д дунд түвшний гүйцэтгэгч, 28,1%-д удирдлагын түвшинд ажиллаж байгаа нь олон улсын болон монгол улсын (улсын болон хувийн) их, дээд сургуулиудын үнэлгээтэй харьцуулсан үнэлгээгээр өндөр түвшинд үнэлэгдэж байна гэсэн үг.

#### **Анхаарах асуудал:**

- Төгсөгчдөд бизнес загварыг бүхэлд нь харах практик дадал, чадвар эзэмшүүлэх, мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргахад дижитал технологи, сошиал медиа хэрэглэгдэхүүн ашиглах чадвар дадал олгох, монголын бизнесийн бодит кэйс дээр ажиллах боломж бүрдүүлэх, хувийн карьер төлөвлөлт хийх чадвар олгоход анхаарах хэрэгтэй.

#### **Зөвлөмж:**

1. Ажил олгогч, төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлагын үр дүнгээс харахад Танилцах, үйлдвэрлэлийн дадлагыг албан ёсны гэрээ, зааварын дагуу оюутан төгсөөд ажиллах бизнесийн салбар чиглэл, нэгжийн дагуу хийлгэхэд анхаарах.
2. Дадлагыг дадлага удирдах багш, дадлага хийлгэх байгууллагын ажилтаны хамтран зохиосон удирдамжын дагуу 2 талын хяналтын дор хийлгэснээр үр дүн өснө.

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Суралцаж буй гадаад оюутны тоо
- Олон улсын хамтарсан хөтөлбөрийн хэрэгжилт
- Улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт
- Олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрөөр 1 гадаад оюутан төгссөн, дахин гадаад оюутнууд элсүүлэн сургахын тулд сургалтын хөтөлбөрт гадаад хэл дээр судлах хичээлүүдийн тоог нэмэхээр төлөвлөн бэлтгэл хангаж ажиллаж байгаа нь сайшаалтай байна.
- Гадаад орны их дээд сургуультай хамтран оюутан солилцоо, дадлага хэрэгжүүлдэг туршлагатай.
- Улсын болон олон улсын уралдаан тэмцээнд оюутнууд амжилттай оролцдог туршлага бүрдүүлсэн байна. .
- Төгсөгчдөөс олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж 5 доктор, 53 магистрын зэрэг амжилттай хамгаалсан байгаа нь бас нэг давуу тал.
- БНСУ-ын Улсаны их сургууль, Тайваны үндэсний нэгдсэн их сургуулийн хамтарсан магистрын хөтөлбөр хэрэгжүүлсэн, Болгарын Варнагийн менежментийн их сургуулийн хамтарсан хөтөлбөр амжилттай хэрэгжиж байгаа туршлагатай.
- Мэргэжлийн дотоодын олимпиадуудад амжилттай оролцож эхний байруудыг эзэлдэг, Олон улсын түвшинд Тайван, Оросын холбооны улсын, бизнес төслийн тэмцээнд тэргүүн байруудад шалгарч байсан амжилтууд олон байна.
- Төгсөгчид олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн 35% суралцсан. Үүний 58% гадаадын их дээд сургуулиудад, 1% ШУТИС-ийн бусад мэргэжлийн сургуульд, 32% ШУТИС-ийн БАТС-д хамрагдсан гайхалтай амжилтууд байна

#### **Анхаарах асуудал:**

- Бакалаврын түвшинд гадаад оюутан татан сургах орчин болон сурах орчинг бүрдүүлэхэд анхаарах
- Олон улсын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, оюутан солилцоо, дадлага хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, өргөжүүлэх

#### **Зөвлөмж:**

1. Багш нарыг мэргэжлийн хичээлийг гадаад хэл дээр заах, бие даалт кэйс ажилбаруудын гадаад хэл дээр бэлтгэхэд сургаж хөгжүүлэх
2. Мэргэжлийн гадаад поктор, профессоруудтай хамтран ажиллах, олон улсын мэргэжлийн холбоодод элсэх, хурал зөвлөгөөнд хамтарсан судалгааны илтгэл хэлэлцүүлэх, төсөл бичихэд анхаарч ажиллах

#### **7.4. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтийг үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол хангадаг байдал
- Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- UNIMIS програм, Social media ашиглан хөтөлбөрийн үйл ажиллагааны мэдээллийг ил тод дэлгэрэнгүй хүргэхэд анхаарч ажилладаг туршлага өндөр байна.

#### **Анхаарах асуудал:**

- Вебсайтын иж бүрэн байдал сайн атал тогтмол ажиллагааны хувьд анхаарахаар байна.
- Веб нь зөвхөн сургуулийн дотоод хуралын мэдээ түгээгч биш, олон нийт рүү чиглэсэн мэдээ мэдээлэл байвал сайн байна

**7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## ШАЛГУУР 8. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

**8.1.** Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол, давтамжтай хийдэг байна.

### Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуултыг хангах удирдлага, зохион байгуулалтын шийдэл, үр дүн
- Дотоод чанарын баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоо
- Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж өөрийн үнэлгээг хийдэг байдал
- Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор судалгааны үр дүнг хөтөлбөрийн ахиц, дэвшилд системтэйгээр ашигласан байдал
- Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг хянасан байдал
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд эргэх холбоо үүсгэх

**Шалгуурыг хангасан байдал:** **Бүрэн хангасан**

### Онцлог зүйл/Туршлага:

- “Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг хангах удирдлага, зохион байгуулалтын шийдэл”, “Хяналт, үнэлгээний үйл явц”-ыг зураглан тодорхойлж, оюутны сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, Явцын үнэлгээ, оролцогч талуудын үнэлгээ, гүйцэтгэлийн үнэлгээ, хөтөлбөр, санхүүгийн байдалд ахиц дэвшлийн үүднээс шинжлэн үнэлсэн нь хөтөлбөрийг чанарыг баталгаажуулах, сургалтын чанарыг сайжруулах үндсэн үнэлгээ болсон байна.
- ШУТИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороо, салбар чиглэлийн дэд хороо хагас жил тутам үнэлж сургуульдаа тайлагнадаг тогтсон журам бүрдсэн байна. Мөн тухайн хичээлийн ахлах багш, дэд профессор, тэргүүлэх профессор, оюутны санал асуулганд үндэслэн үнэлэлт өгч сайжруулалт хийдэг ба үүнийг ажлын чиг үүргийнхээ дагуу сургалтын бодлого чанарын алба, салбар сургуулиудын захирал ханган ажилладаг байна.
- Удирдлага зохион байгуулалт, хяналт үнэлгээ хийх хэлбэр бүрэн тодорхойлогдож UNIMIS програмаар зохицуулагдаж байна. Чанарын удирдлагын нэгдсэн системийг хангахад UNIMIS програм бүрэн зориулагдан боловсрогдон хэрэглэгдэж байгаа давуу тал байна.
- Сургалтын албанаас улирал бүрийн төгсгөлд оюутан бүрээс профессор багш нарын заах арга барил, ур чадвар, хичээлийн ном сурах бичгийн хүрэлцээ зэрэг үзүүлэлтээр санал асуулга авч улирал тутам үр дүнг тайлагнаж, түүний мөрөөр тодорхой ажил зохион байгуулж хэвшсэн нь хөтөлбөрийг үр дүнд үнэлэлт өгөх, түүнийг сайжруулахад ихээхэн тус дөхөм болдог байна.
- Хөтөлбөрт оролцогч талуудаас авсан судалгааны үр дүнд үндэслэн хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, багшийн хөгжил, сургалтын чанар, үйл ажиллагааг сайжруулж, үр дүнг хянаж, зах зээлийн хэрэгцээ, цаг үеийн байдал, ажлын байрны өөрчлөлт, ажил олгогчийн шаардлага зэргийг харгалзан хөтөлбөрийг байнга сайжруулан шинэчилж байна гэж тайланд тусгасан байна.
- Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангаж ажиллахдаа оюутны болон төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, ажил олгогчдын болон мэргэжлийн хөндлөнгийн гүйцэтгэлийн

үнэлгээ, үр нөлөөний үнэлгээ, хөтөлбөрийн санхүүгийн байдлын шинжилгээ, үнэлгээ, хөтөлбөрийн чанарын үнэлгээ гэх зэрэг аргуудыг хэрэглэдэг давуу тал байна.

- Үндэсний зөвлөлцөлд хүсэлт гарган бакалаврын 6 хөтөлбөрийг 2011-2015 онд итгэмжлэл хийлгэсэн. Олон улсын магадлан итгэмжлэлийн зөвлөлд хүсэлт гарган 2013 онд ACBSP магадлан хийлгэсэн ба 2015 онд ахиц дэвшлийн тайлан илгээн баталгаажуулсан байна.
- Судалгааны үр дүнг ашиглан хөтөлбөрийн үр дүнг сайжруулах ажлыг жил бүр үндсэн таван чиглэлээр зохион байгуулсан байна.
- Е-нээлттэй институтын хүрээнд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд эргэх холбоо үүсгэх асуудлыг цогцоор шийдвэрлэн ажиллаж байгаа тэргүүн туршлага байна.

**Анхаарах асуудал:**

- Сургалтын хөтөлбөрийг чанарыг баталгаажуулахдаа олон төрлийн санал асуулга, судалгаа хийх замаар сайжруулалт хийхэд анхаарах

**Зөвлөмж:**

1. Сургалтын хөтөлбөрийг чанарыг баталгаажуулах маркетингийн судалгааг олон нийтийн санал асуулга, ярилцлага, нээлттэй хэлэлцүүлэг, форум, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах гэм мэт төрөл бүрийн аргаар судалгаа хийж үнэлдэг механизм бүрдүүлэх
2. Хөтөлбөрийн чанарыг үнэлэх үндсэн (гол) багц хэмжүүрүүдийг боловсруулан үр дүнд тулгуурлан хөтөлбөрийн чанарыг сайжруулж байх

**8-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шинжээчийн шаардлага ба дүгнэлт:

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	+		
2	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	+		
3	Хөтөлбөрийн удирдлага, зохион	+		
4	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	+		
5	Багшийн үйл ажиллагаа	+		
6	Сургалтын үйл ажиллагаа	+		
7	Хөтөлбөрийн үр дүн, нөлөө	+		
8	Чанарын үнэлгээ баталгаажилт	+		
Нийт				

## ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭЦСИЙН ДҮГНЭЛТ:

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн “Бизнесийн удирдлага” багцийн 5 бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнес, удирлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ...../Г.Болдбаатар/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Ц.Нансалмаа/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Б.Мөнхбаяр/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../С.Энхсайхан/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Б.Ундрал/

**Шинжлэх Ухаан, Технологийн их сургуулийн Бизнесийн удирдлага,  
хүмүүнлэгийн сургуулийн “Бизнесийн удирдлага” D041301 багцийн  
сургалтын хөтөлбөр**

**Сургууль дээр ажиллах төлөвлөгөө**

Огноо: 2018-05-02 Лхагва гараг 09.00-18.00 цаг  
2018-05-03 Пүрэв гараг 09.00-18.00 цаг

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн
<b>2018-05-02 Лхагва гараг</b>		
09:00-09:30	ШУТИС Идээр ирж ажиллана. Сургалт, хөтөлбөр хариуцсан удирдлагатай уулзах	Өөрийн үнэлгээний багийн ахлагч
	Шинжээчийн багийн бүрэлдэхүүн, магадлан итгэмжлэлийн үйл явцыг товч танилцуулна.	Зохицуулагч Шинжээчийн багийн ахлагч
09:30-11:00	ШУТИС-ийн төв номын сан, Е-нээлттэй институттэй танилцах	Шинжээчид
11:10-11:40	ШУТИС-ийн БУХС дээр ажиллана. - Шинжээчийн багийг танилцуулна. - Магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулна.	Зохицуулагч Шинжээчийн багийн ахлагч
11:40-12:30	Удирдлага болон Өөрийн үнэлгээний багтай уулзах: -Удирдлагын бэлдсэн хөтөлбөрийн товч танилцуулга -Шинжээчид хөтөлбөрийн багаас ӨҮТ-тай холбоотой тодруулах зүйлсийг асуух	Өөрийн үнэлгээний багийн ахлагч
12:30-13:30	Өдрийн хоол	
13:30-14:00	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцана.	Шинжээчид
14:00-15:00	БУХС-ийн сургуультай танилцах: Номын сан болон лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцана	Шинжээчид
15:00-16:00	Өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримттай танилцах	Шинжээчид
16:00-17:00	Төгсөгчидтэй хийх уулзалт	Шинжээчид
17:00-18:00	Ажил олгогчидтой хийх уулзалт	Шинжээчид
<b>2018-05-03 Пүрэв гараг</b>		
09:00-10:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	Шинжээчид
10:00-11:00	Оюутнуудтай хийх уулзалт	
11:00-11:10	Завсарлага	
11:10-12:10	Багш нартай хийх уулзалт	
12:10-13:10	Өдрийн хоол	
13:10-14:10	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	
14:10-17:00	Шинжээчид дүгнэлтээ хэлэлцэн, гаргана. Нэмэлт материал үзэх танилцах /Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/	
17:00-18:00	Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.	

I. Ярилцлагад оролцсон оролцогчдын жагсаалт  
1. Багш нарын нэрс

№	Профессор, багш нар	Уулзсан багш нар
1	П.Жаргалтуяа	+
2	Б.Энхтуяа	+
3	Х.Ариунаа	
4	Б.Даваасүрэн	
5	Г.Гантөгс	
6	Да.Баярмаа	
7	Ц.Энхчимэг	
8	Ц.Гүнбилэг	
9	Д.Ганболд	
10	Л.Цэрэнчимэд	
11	Ц.Баярцог	
12	С.Соёл-Эрдэнэ	
13	Д.Ариунжаргал	+
14	А.Аюуш	
15	М.Саруул-эрдэнэ	
16	Д.Оюунчимэг	+
17	Д.Оюунгэрэл	+
18	Г.Тунгалагтуяа	
19	Ч.Нямбаяр	
20	Т.Тамир	+
21	Г.Цолмон	
22	Ч.Энх-Амар	+
23	Д.Отгонсүрэн	+
24	Ё.Мөнхтуяа	
25	Э.Даариймаа	
26	М.Сарантуяа	+
27	Т.Золжаргал	
28	Н.Эрдэнэтуяа	+
29	До.Баярмаа	
30	Б.Бат-Эрдэнэ	+
31	Ц.Мөнхтуяа	
32	М.Анхбаяр /салбарын эрхлэгчийн туслах/	

## 2. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1	Ариунзаяа	ОУБМ III	Дотуур байр, дархан
2	Түмэнбаяр	ОУБМ IV	
3	Есөнтөмөр	ОУБМ III	Варна сургуулийн солилцооны 2017-2018 оны зайны хөтөлбөрт хамрагдан виза нь гарсан. Олон улсын маркетингийн улсын IV олимпиадад багаараа III байр эзэлсэн
4	Золзаяа	ОУБМ III	Сингапурт суралцаж байгаад шилжиж ирсэн. Олон улсын маркетингийн улсын IV олимпиадад багаараа III байр эзэлсэн
5	Адъяа	ОУБМ III	Ангийн дарга. Олон улсын маркетингийн улсын IV олимпиадад хувийн дүнгээр III байр эзэлсэн
6	А.Золзаяа	ХНМ IV	Оюутны байр /Өвөрхангай/
7	Ч.Халиун	ХНМ IV	ХНМ-ийн улсын олимпиадад оролцогч
8	Т.Тэмүүжин	ХНМ IV	Оюутны байранд амьдардаг.
9	П.Сувд-Эрдэнэ	ХНМ III	Шилжиж ирсэн оюутан
10	Р.Алтангэрэл	ХНМ III	Оюутны байр
11	А.Уянга	МСМ III	Төв аймгийн Угтаал цайдам сум
12	Л.Даваарагчаа	МСМ III	Оюутны байр
13	Э.Ганзориг	МСМ III	"Gund health and education" сангийн тэтгэлгээр сурдаг. Буриад улстай хамтарсан гарааны бизнесийн тэмцээнд шалгарсан
14	Э.Дөлгөөнтамир	МСМ IV	УБ хот
15	А.Уринцэцэг	МСМ IV	Хичээлийн хажуугаар ажил хийдэг
16	Г.Ануужин	ММ IV	Ангийн дарга. 2018 онб маркетингийн менежментийн улсын олимпиадад Д.Дагвадоржийн нэрэмжит шагналт
17	Т.Буянцог	ММ IV	Оюутны байранд
18	Э.Бадамсүрэн	ММ IV	Хагас өнчин
19	Ц.Энхболд	ММ III	ММ олимпиадад оролцогч
20	А.Рагчаадулам	ММ III	Оюутны байранд. Японд дадлагажих хөтөлбөрт хамрагдсан
21	Б.Цэндсүрэн	ММ III	Шилжиж ирсэн
22	Б.Дөлгөөн	ММ III	Варна сургуулийн солилцооны 2017-2018 оны зайны хөтөлбөрт хамрагдан виза нь гарсан. Олон улсын маркетингийн улсын IV олимпиадад багаараа III байр эзэлсэн
23	Идшидэнноров	ММ IV	Оюутны байр
24	Урангоо	СМ IV	Оюутны төлөөлөл, магистрт давхар сурдаг
25	Отгонзул	СМ IV	Оюутны төлөөлөл
26	Баасанхүү	СМ III	Оюутны төлөөлөл
27	Амарзаяа	СМ III	Оюутны төлөөлөл
28	Н.Золбоо	СМ IV	Оюутны төлөөлөл

## 3. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Ажлын газар	Албан тушаал
1	Х.Бадамгэрэл	Андра модель агентлаг	Ерөнхий захирал
2	Д.Сүхбаатар	Шунхлай ХХК	Борлуулалт, маркетингийн газрын

			захирал
3	Түмэннаст	Брэндмарк ХХК	Маркетингийн зөвлөх
4	Э.Уянга	Монголын ББСБ-ын холбоо	Гүйцэтгэх захирал
5	А.Жавхлантөгс	Хан Имperiал ХХК	Гүйцэтгэх захирал
6	Ө.Гэрэлмаа	Ландекс тээвэр зууч	захирал
7	Төмөрбаатар	Гангар	Албаны дарга
8	Г.Отгонтуяа	Монгол контент	Төслийн албаны дарга
9	Намжилмаа	Сангийн яам	Ахлах
10	Бодьгэрэл	Cashmere concept LLC	Захирал
11	О.Золзаяа	Нийслэлийн архивын газар	Системийн шинжилгээ хариуцсан менежер
12	Б.Эрдэнэбаяр	Супер ассест системс ХХК	Захирал
13	Г.Баттөгөлдөр	Инфософт ХХК	Захирал
14	Б.Баттөр	Интерактив ХХК	Төсөл хариуцсан захирал
15	Б.Жавхлан	Могоул сервис анд саппорт ХХК	Гүйцэтгэх захирал
16	Даваасамбуу	Үнэт цаасны бирж	Захирал
17	А.Алтансүх	ББСБ	Захирал
18	И.Алтантулга	Ittools ХХК	Гүйцэтгэх захирал
19	Ц.Энх-Амгалан	ИЗИС	Эрхлэгч
20	Э.Пүрэвлхам	Таванбогд	Санхүүгийн албаны дарга
21	Мягмаржав	Юнител	Санхүүгийн албаны дарга
22	Д.Анхзул	Витафит ХХК	ХНалбаны дарга
23	Ч.Амарзаяа	Тэсо корпораци	ХНалбаны дарга
24	Ц.Түвшинтөр	MCS кока кола	ХНалбаны дарга
25	Б.Цолмон	Мак ХХК	Байгууллагын хөгжлийн газрын дарга
26	Д.Нямлхаажав	Макс групп	ХНалбаны дарга

#### 4. Төгсөгчдийн нэрс:

№	Овог нэрс	Төгссөн он	Мэргэжил
1	Ц.Баатарцогт	2015	Маркетингийн менежмент
2	М.Одгэрэл	2014	Маркетингийн менежмент
3	Т.Наранбаатар	2013	Маркетингийн менежмент
4	Б.Уянгатөгс	2017	Маркетингийн менежмент
5	М.Үжин	2017	Маркетингийн менежмент
6	Н.Эрдэнэжаргал	2010	Хүний нөөцийн менежмент
7	С.Дэлгэрмаа	2013	Хүний нөөцийн менежмент
8	Г.Одгэрэл	2010	Хүний нөөцийн менежмент
9	Г.Отгонцэцэг	2015	Хүний нөөцийн менежмент
10	Ц.Баасандорж	2016	Хүний нөөцийн менежмент
11	Г.Солонго	2014	Хүний нөөцийн менежмент
12	Б.Даваасүрэн	2004	Олон улсын бизнесийн менежмент
13	Б.Ариунбилэг	2009	Олон улсын бизнесийн менежмент
14	Л.Уранзаяа	2015	Олон улсын бизнесийн менежмент
15	Г.Галбаяр	2005	Олон улсын бизнесийн менежмент
16	О.Гантулга	2016	Мэдээллийн системийн менежмент
17	П.Уртнасан	2017	Мэдээллийн системийн менежмент
18	А.Акмарал	2014	Мэдээллийн системийн менежмент
19	Б.Төгөлдөр	2015	Санхүүгийн менежмент
20	Э.Базарваань	2015	Санхүүгийн менежмент
21	Г.Дөлгөөн	2017	Санхүүгийн менежмент
22	Н.Энх-Амгалан	2012	Санхүүгийн менежмент

## Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН  
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД**

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛЬ**

**БИЗНЕСИЙН УДИРДЛАГА  
ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ**

11161, Улаанбаатар хот, Бэлсүрэг дүүрэг,  
3-р хороо, ШУТИС-ийн V хурал буйр, 119-49/111  
Урсал: (976-11) 45-81-51, Факс: (976-11) 45-81-51  
http://www.shu.edu.mn, Email: secretary.shu@shu.edu.mn

2018.05.21 № 298

тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Шинжээчийн тайлангийн хариу

ШУТИС-ийн БУХС Бизнесийн удирдлагын D041301 кодтой Санхүүгийн удирдлага, Хүний нөөцийн удирдлага, Маркетингийн удирдлага, Мэдээллийн системийн удирдлага, Олон улсын бизнесийн удирдлагын багц хөтөлбөрийг захирлын 2017 оны 10 сарын 30 өдрийн А-98 тоот тушаалаар магадлан итгэмжлүүлэхээр шийдвэрлэсэн.

БМИУЗ-д хүсэлтээ гарган 2017 оны 12 сарын 18-ны өдөр сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх үйл ажиллагааны гэрээг байгуулсан. Ажлын төлөвлөгөөний дагуу хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан, хавсралтыг хүргүүлсэн. 2018 оны 5 сарын 2, 3-ны өдөр шинжээч нар тус сургууль дээр ажиллаж, илрэл, нотолгоотой танилцсан.

БУХС 2018 оны 5 сарын 17-нд шинжээчийн тайлан, дүгнэлтийг хүлээн авлаа. Тайланд сургалтанд мэдээллийн технологи, программ хангамжийг түлхүү ашиглах, багш оюутанд чиглэсэн шинээр санаачлан хэрэгжүүлж буй үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмжийг өгсөн байна. БУХС нь ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль тул хөтөлбөрийн эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаанд нэгдсэн нэг удирдлагын мэдээллийн системийг мөрдөж ажилладаг болно.

Шинжээчийн тайланд тусгасан сургалтын хөтөлбөрийг цаашид сайжруулах, хөгжүүлэхэд чиглэсэн дүгнэлт, зөвлөмжийг хүлээн авч, ажилдаа тусган ажиллах болно.

ЗАХИРАЛ  А.ЭНХБАТ

